

Монгол хэлний тэмдэг нэрийн захирах чадвар

М.Базаррагчаа

(Монгол Улсын Их Сургууль)

Монгол хэлний жинхэнэ нэр нь харьяалах, жишихийн тийн ялгалын нөхцөлөөр жинхэнэ нэрийг захирдаг (үхрийн эвэр, чоно шиг нохой) бол орон цагийн нэр нь харьяалах, гарахын тийн ялгалын нөхцөлөөр жинхэнэ нэрийг захирдаг (уулын цаана, гэрээс наана). Тэгвэл тэмдгийн нэр нь заахын тийн ялгалаас бусад нөхцөлөөр жинхэнэ нэрийг захирна (Морь-□ нь сайн, Хүний сайныг ханилан байж мэднэ, Манай нутаг булаг шандаар элбэг. Ураг урагтаа хүнд, Ургаа мод газартаа хүнд; Найрын богино нь сайн, насны урт нь сайн; Цэцгээ ахтай дотно, Эрхтнээс чих хэлтгий, эдлэлээс домбо хэлтгий, Эрдэнээс дун хэлтгий; Дээвэр хоолойгоороо татуу, дээл захаараа татуу, уул оройгоороо татуу, Нойтонд цавуу бөх, маханд элэг бөх, амьтанд заан бөх; Тостойгоос тогоо хар, билэгтэйгээс бэх хар, амттайгаас архи хар; Газар үндсээр баян, тэнгэр одоор баян, далай усаар баян; Уурнаас балтгар, уулнаас өндөр, хөөнөөс хар, хөвөнгөөс цагаан (шаазгай); Сар шиг дугаргий, сам шиг сандархай (Тооно). Говь руу ургац муу)

Орон цагийн нэр нь харьяалах ба гарахын тийн ялгалын нөхцөлөөр жинхэнэ нэрийг захирдаг (Уулын цаана туулайн хэвтэр (Шилний хонхор). Гэрийн хойно гэдэн годон (Өрхний оосор). Тэнгэрийн хаяанаас цааш газаргүй хэмээн сэтгэсээр ... (Д.Н) Хурдлан довтлох уурын тэрэгний өмнөөс (Д.Н)

Ийнхүү тэмдэг нэр нь заахын тийн ялгалын нөхцөлөөр өмнөх жинхэнэ нэрийг захирдаггүйгээрээ үйл үгээс ялгаатай боловч жинхэнэ нэр ба орон цагийн нэрийг бодвол захирах чадвараараа үйл үгтэй ойр юм. Тэмдэг нэрийн захирах чадварын талаар Л.Мишиг¹, Г.Д.Санжеев², Ш.Лувсанвандан³, Г.Ц.Пюрбеев⁴, Л.Бэшэ⁵ нар судалсан байна. Эдгээрийн дотроос Г.Ц.Пюрбеев сонгодог болон орчин үеийн халх, ойрод, халимаг, буриад хэл аялгууны баялаг хэрэглэгдэхүүний холбоо үгийн жишээнээс эшилж, өгөх-орших, гарах, үйлдэх, харьяалах, холбох тийн ялгалаар жинхэнэ нэр ба цагт нэрийг захирсан тэмдэг нэр бүхий холбоо үгийг утгаар нь ялгахыг оролдсон байна. Үүнд, гарахын тийн ялгалаар өмнөх жинхэнэ нэрийг захирсан тэмдэг нэрт холбоо үг нь:

1. Харьцуулсан утгатай (*hodun-ača olan* (НТ. §105), *köbegün-eče alus* (АТ. 1-37), *tngri nere-yin ökin-eče γayiqamsiytu* (К.М.Черемисов, 1937),

¹ Л.Мишиг. Монгол хэлний холбоо үгийн зүйл, Уб., 1957, 24-25-р т.

² Г.Д.Санжеев. Сравнительная грамматика монгольских языков. Глагол.М., 1964, стр.5

³ Ш.Лувсанвандан. Монгол хэлний үгсийг аймаглах тухай асуудалд, “Хэл зохиол” V боть, Уб., 1967 (1968). 34-35-р т.; Орчин цагийн монгол хэлний бүтэц. Монгол хэлний үг нөхцөл хоёр нь, Уб., 1968. 24-р т.

⁴ Г.Ц.Пюрбеев. Историко-сопоставительные исследования по грамматике монгольских языков. Синтаксис словосочетания, М., 1993, стр. 144-159

⁵ Л.Бэшэ. Монгол хэлний нэрлэсэн өгүүлбэрийг хувилгах нэг байдал

mindasun-āṣa jögölen (А.Позднеев, 1911), Гангаамаагаас дүү, сүүнээс цагаан, харсагаһаа хурдан (буриад), чолунас хату (халимаг), хөөнэс номһн (халимаг).

2. Тоо хэмжээний утгатай (*ebedüg-ēce ileü* (НТ. §57), *köbegüd-ece odqan-anu* (Ц.Б.Цыдендамбаев. 1972))
3. Учир шалтгааны утгатай (*tegri-dēce jayayātu* (АТ. 1.4), *noqai-āṣa ṣoṣimtayai* (НТ. §66))
4. Орон цагийн утгатай (городхоо хол (буриад), гэрэс уужим (халимаг), бичкнэсн гэмтэ (халимаг), асхнас бэлн (халимаг)⁶ гэж ангилжээ. Мөн “*aduγusun-dur amaray, barilduyan-dur batu*” гэвэл “хязгаарласан” утгатай бол “*beye maqabud-tu qourtai, kegēli qaquuli-dur duratai*” гэхэд “ерөнхийлсөн” утгатай ба “*herekei-dur honičitan* (НТ. §139), *erdem-dü duratan*” гэвэл “онцлон ялгасан” утгатай, “*ükül-dü oyira* (М.А. 1938), *yertünčü-dü qubitai* (Х.Лувсанбалдан, 1976), нуруундаа эмзэг, хошуундаа цагаан, наранда эли (буриад), күзүндэ алг (халимаг)” гэвэл орон цагийн утгатай, “*merged-tü keregtei* (Х.Лувсанбалдан, 1976), дөрлдэнд бэлн (халимаг), хүдэлмэридэ шухал (буриад) гэвэл зорилго заасан утгатай болох ажээ.

Монгол хэлний “адил, сацуу” гэсэн тэмдэг нэр нь өмнөх жинхэнэ нэрээ холбохын тийн ялгалын нөхцөлөөр холбож, “*ere-lügē saṣai* (НТ. §21). *Adoṣun-luγā adali* (Х.Лувсанбалдан, 1976), бухин өврлэ эдл, ангин соялā эдл (халимаг) гэсэн жишээ татжээ⁷.

Г.Ц.Пюрбеев тэмдэг нэрийн найрсан холбоо үгнээ 1. Сайны сайн, дээдийн дээд, хараһаа л хар (хараас хар); 2. *güičen* γо’а, *üküme* соγтуу, төрөхөөс шулуун шударга, 3. *Ketürkei mergen*, *yeke küčütei*, *asaru tomu*, бузар хайн, аагим халуун, бат сайхан, *asaru gün*, шал нойтон, цэв хүйтэн, *ürgüljide sayin*, залуһаа буурал (залуугаараа буурал) гэх мэт холбоо үгийг оруулсны эхнийх нь давтсан хэлц холбоо үг, дундах нь цагт нэр нь тэмдэг нэрийн өмнө тийн ялгалын нөхцөлтэй, эсвэл нөхцөлгүй орсон, сүүлчийнх нь мөн тэмдэг нэрийн өмнө тэмдэг нэр орж, давуу зэргийг илтгэх болсон ба угтвар бүтээврүүд мөн тийм утгаар тус тус орсон нь хувилбар холбоо үгс болно. Үүнд,

1. Дээд зэргийн чанартай эд (орны утга бүхий нэр нь хэмжээ дэв дэсийн утгат нэрнээ хавсарчээ)
2. Мундашгүй хүчит бөх (үгүйсгэсэн утга бүхий цагт нэр)
3. Бүхнээс хүчит арслан (бүх (бөхчүүд)-ээс хүчтэй гэснээс хураасан нь)
4. Хэтэрхий нарийн саваа (тэмдгийн нэрээр давуу зэргийг илтгэжээ)
5. Нэлээд их тариа (тэмдгийн нэрээр давуу зэргийг илтгэжээ)
6. Туйлын чухал баримт (бодит нэрээр давуу зэргийг илтгэжээ)
7. Хамгаас хүчит бөх (хамаг (бөхчүүд)-ээс хүчтэй гэснээс хураасан нь)
8. Үхмээр согтуу (боломжийн утга бүхий цагт нэр)
9. Их жаргалтай (тэмдгийн нэрээр давуу зэргийг илтгэжээ)

⁶ Г.Ц.Пюрбеев. Дурдсан зохиол, стр. 149-152

⁷ Г.Ц.Пюрбеев. Дурдсан зохиол, стр. 154

10. Ийм сайхан нутаг (тэмдэг нэрийн төлөөний үгээр давуу зэргийг илтгэжээ)

11. Аагим халуун өдөр (тэмдгийн нэрээр давуу зэргийг илтгэжээ)

12. Үргэлжид сайн нөхөр (цагийн нэр нь угтаа давуу зэргийг илтгэхгүй юм)

гэх мэтээр тэмдэг нэрийн өмнө хамжин ба найран орсон үгс нь тэмдэг нэрийн давуу зэргийг илтгэх утгвар бүтээвэр (маш, нэн, тун, цоо ув улаан, цав цагаан, шал нойтон, цэл, цал, асар, улам, тас хар, тэс хөндлөн, пиг дүүрэн, пад хар, час улаан)-ийн оронд хэрэглэгддэг билээ.

Орон цагийн нэр нь өмнөх үгээ зөвхөн гарах, харьяалахын тийн ялгалаар захирдаг шиг тэмдэг нэрийн давуу зэргийг үгээр илтгэхэд энэ хоёр тийн ялгал хэрэг болдог нь сонин тохиолдол юм.

а). 1. Туйл $\left\langle \begin{array}{c} \text{ЫН} \\ \text{аас} \end{array} \right\rangle$ сайн морь 2. Гэр $\left\langle \begin{array}{c} \text{ИЙН} \\ \text{ээс} \end{array} \right\rangle$ хойно, үд $\left\langle \begin{array}{c} \text{ИЙН} \\ \text{ээс} \end{array} \right\rangle$ өмнө

б). Сайхан $\left\langle \begin{array}{c} \text{Ы} \\ \text{аас} \end{array} \right\rangle$ сайхан бүсгүй, хол $\left\langle \begin{array}{c} \text{ЫН} \\ \text{оос} \end{array} \right\rangle$ хол газар, айхавтар $\left\langle \begin{array}{c} \text{ЫН} \\ \text{аас} \end{array} \right\rangle$ айхавтар хүн

Энэ жишээний хоёрдогч (б) нь тэмдэг нэрийг давтаж, уул хоёр тийн ялгалаар холбож, тэмдэг нэрийн давуу зэргийг задлаг аргаар илтгэж байна. Энэ тухай Л.Мишиг тэмдэглэжээ⁸.

Харин “хэрцгий догшин, яруу тодорхой, хүчир хүнд (хүнд хүчир) зэрэг нь зэрэгцэх утгат тэг холбоосоор холбогдсон хоршоо үг бол “үнэхээр сайхан”, *арай* хурдан, уулаасаа эцэнхий, *ерөнхийдөө* шуугиантай” гэвэл “үнэхээр, арай, ерөнхийдөө” зэрэг нь баймжийн утгат үг болно. Мөн “үргэлжид сайн, насад тахир, залуугаасаа буурай, асханд сайхан (асхнд сеахн), өглөө хүйтэн (орунд кийтэн), дотогш махир, эндээсээ хол, дотроо хөндий, “урьднаасаа тунгалаг” гэвэл тэмдгийн нэр нь өмнөх үгээ өгөх-орших, гарахын тийн ялгал, орон цагийн нэрийн тэг үндсээр өмнөх үгээ захирсан байна.

Л.Бэшэ “Qorči irejü ögüleriin: Bodončar boydo-yin bariju abuysan eme-dece töregeen bajamuqa-lu’ā ke’eli nigeten, keke γaγčatan büle’ei (НТ. §121): ... helige-dür sölsütü, herekei-dür hončitan, a’üsgi dügüreng jirüketü, aman dügüreng a’ürtan, ere tutum erdemten, böküs küčüten-i ilγaju ögsü (НТ. §139) жишээ татаж, –ke’eli nigeten, keke γaγčatan büle’ei’ гэсний “nigeten, γaγčatan гэдгийг өгүүлэхүүн гишүүн гэсэн бол,

-a’usgi dügüreng jirüketü

aman dügüreng a’ürtan

ere tutum erdemten,

böküs küčüten-i ... гэхэд,

“-a’üsgi dügüreng, aman dügüreng, ere tutum erdemten” гэснийг тэмдэг нэрийн тодотгол, böküs küčüten-i гэдэг нь шууд тусагдахуун гэж үзсэн байна⁹.

⁸ Л.Мишиг. Монгол хэлний холбоо үгийн зүйл, Уб., 1975, 25-р т.

⁹ Л.Бэшэ. Монгол хэлний нэрлэсэн өгүүлбэрийг хувилгах нэг байдал,

Гэвч 139-р зүйлд буй “ялгаж өгч” гэсэн өгүүлэхүүнд зургаан нэр өгүүлэхүүний өгүүлбэр зэрэгцэн захирагдсан ба, дүүрэн” гэсэн тэмдгийн нэр нь тодотгол гишүүн өгүүлбэрийн төгс бус өгүүлэхүүн болно.

Л.Бэшэ “*nige ke'eliten, sulsütü elige, dü'üreng a'urtan am*” гэсэн хамжсан тодотгол гишүүн байснаа “*ke'eli nigeten*” гэж өгүүлэхүүн гишүүн болон тонгорсон гишүүн юм гэсэн нь зөв юм. Гэвч монгол хэлний тэмдэг нэр нь өгүүлбэрт тодотгол өгүүлэхүүн болдог гэснийг зөвшөөрч болохгүй юм. Тэмдгийн нэр нь ямагт нэр үйлийн өмнө хамжсан тодотгол гишүүн л болно. Тэрээр, “Тодотголыг нэг төрлийн өгүүлэхүүн гэж болмоор байна” гэсэн нь нэг талдаа, тэмдэг нэр нь өмнөх жинхэнэ нэр гишүүнийг заахаас бус тийн ялгалаар захирна гэсэн санаа байж болох ч нөгөө талдаа, тэмдэг нэр нь дотоод бүтцийн буюу хэлэгдэхүүний үүднээс хэзээ ч өгүүлэхүүн болохгүй юм. Харин “бай-, бол-” үйл үг ардаа авбал сая өгүүлэхүүний шинжтэй болно. Жишээ нь:

Сайхан үнэртэй (байсан) энэ хатуу хүрэн (болсон) дарсыг Чүлтэм бас л урьд өмнө нь ууж үзсэнгүй (С.Э) гэвэл үйлшсэн тэмдэг нэр нь өгүүлэхүүн болно. Энэ амгалан их (болсон) усны дэргэд юм бодохгүй байхын аргагүй [Ø] (С.Э) гэхэд, “аргагүй” хэмээх тэмдэг нэр үйл өгүүлэхүүний байрнаа орсон тул үйлшиж, ардаа тэг холбоц буюу “бай-лаа” гэсэн үг авсан болох нь мэдэгдэнэ. Гэвч тэмдэг нэр бүр тухайн өгүүлбэрт орохдоо дандаа тэг холбоц аваад байдаггүй. Тухайлбал, Хангайн өндөр уул шиг нөмөр түшигтэй явсан хан буурал эцэг – миний хайрт аав аа! (Б.Я) гэхэд эдгээр тэмдэг нэр нь тэг холбоц авах боломжгүй нь тэмдэг нэрийн үндсэн үүргээс шалтгаалах ба утга найруулга эвдрэхэд хүрнэ, Л.Бэшэгийн авсан өгүүлбэрийн 1. Үзүүр хурц гадас (үзүүр нь хурц байсан гадас), 2. Үзүүр нь маш хурц байна, Үзүүр нь арай хурц байна” гэхэд эхнийх нь тодотгол гишүүн өгүүлбэр, сүүлчийнх нь баймж бүтээвэр, үг бүхий хувилбар энгийн өгүүлбэр юм.

Тэмдэг нэрийн захирах чадварын талаар Ш.Лувсанвандан (Тэмдэг нэр нь гарах үйлдэх, өгөх-оршихын тийн ялгалын хэлбэрт үгийг захирч чадна)¹⁰, П.Бямбасан (Тэмдгийн нэр ... харьяалах ... өгөх орших, гарах, үйлдэхийн тийн ялгалд байгаа өмнөх нэрээ захирч чадна)¹¹ П.Бямбасан (Тэмдэг нэр нь заахаас бусад тийн ялгалаар өмнөх үгээ захирч чадна)¹², Лх. Дамдинжав (Тэмдэг нэр нь өмнөх үгээ өгөх-орших, үйлдэх, гарахын тийн ялгалаар захирна)¹³, Ц.Өнөрбаян (Тэмдэг нэр нь өмнөх үгээ ихэвчлэн өгөх-орших, гарах, үйлдэхийн тийн ялгалаар захирна. Бусад тийн ялгалаар өмнөх үгээ захирах чадвараар сул байдаг. Хэлбэрийн хувьд, нэрлэх, харьяалах, хамтрах, заах, чиглэхийн тийн ялгалтай үгийг захирч байгаа мэт байвч мөн чанартаа тэмдэг нэрийн шинж биш, тухайн тэмдэг нэр нь жинхэнэ нэрийн үүрэг гүйцэтгэсэн ба үйл үг нь хэмнэгдсэн тохиолдолтой

¹⁰ Ш.Лувсанвандан, Орчин цагийн монгол хэл, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, Бээжин 1962, 228-р т.

¹¹ П.Бямбасан. Тэмдгийн нэр, “Орчин цагийн монгол хэл зүй” ШУА, Хэл зохиолын хүрээлэн, Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, Уб., 1966, 104-р т.

¹² П.Бямбасан. “Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг. Ардын боловсролын яамны хэвлэл, Уб., 1975, 58-р т.

¹³ Лх.Дамдинжав, Орчин цагийн монгол хэлний холбоо үг, УБДС-ийн монгол хэлний тэнхим, Уб., 1978, 38-39-р т.

холбож ойлгох хэрэгтэй юм)¹⁴, П.Бямбасан, Б.Базылхан, Ж.Баянсан (Тэмдэг нэр нь заахаас бусад тийн ялгалаар өмнөх үгээ захирч чадна)¹⁵, Б.Бямбадорж (Тэмдгийн нэр нь өмнөх үгээ голдуу өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар захирдаг)¹⁶, Цэнгэлтэй (Тэмдэг нэр нь өгөх орших, гарах, үйлдэхийн тийн ялгалын нэрийг өмнөө захирч чадна)¹⁷, Сунрав, Сэцэн нар (Тэмдэг үг өгүүлбэрт өмнөө гарах, үйлдэхийн тийн ялгалт үгийг захирч чадна)¹⁸, Чойжинжав (Байр солиход тэмдэг нэр нь уг нэр; үйл үгийг захирсан голлох үг болдог (нимгэн цас – цасны нимгэн, нэн их зодох – зодохын ихээр зодох, муу авьяастай – авьяас муутай, сайн нөхөр – нөхрийн сайн), өгүүлбэрт өмнөө гарах, үйлдэхийн тийн ялгалт үгийг захирч чадна)¹⁹, Сэцэн, Цогт нар (Тэмдэг үг өгүүлбэрт өмнөх үгээ харьяалах, өгөх-орших, гарах, үйлдэхийн тийн ялгалаар захирч чадна (Зүсийн сайхан дээлд үгүй, Моринь сайн эмээлд үгүй, Зайдан унаа бөгсөнд муу, зальт мэх биед муу)²⁰, Тулгуур (Тэмдэг нэр нь өгүүлбэрт өмнөө гарах үйлдэхийн тийн ялгалт үгийг захирч чаддаг: Хотоос хол боловч сургуулиас ойр байвал)²¹ зэрэг эрдэмтэд хоёр янз үзсэн байна. Үүнд, тэмдгийн нэр нь өмнөх жинхэнэ нэрийг заахаас бусад тийн ялгалаар захирна. (Ш.Лувсанвандан, П.Бямбасан) гэсэн бол харьяалах, өгөх-орших, гарах, үйлдэхийн тийн ялгалаар захирна (П.Бямбасан, Сэцэн, Цогт нар) гэсэн ба тэмдгийн нэр нь өмнөх үгээ үйлдэх, өгөх-орших, гарахын тийн ялгалаар захирна (Ш.Лувсанвандан, Цэнгэлтэй, Өнөрбаян, Лх.Дамдинжав) гэжээ. Тэгвэл өмнөх нэрээ үйлдэх гарахын тийн ялгалаар захирна. (Тулгуур, Сунрав, Сэцэн нар, Чойжинжав) гэсэн бол өмнөх үгээ үйлдэх, өгөх-оршихын тийн ялгалаар захирна (Б.Бямбадорж) гэжээ. Харин Г.Ц.Пюрбеев өгөх-орших (эрхийдээ оньчтой, сахихад хялбар), гарах (хөвүүнээс алс), үйлдэх (хүйсээр төрөл), харьяалах (эрийн сайн), холбох (эр лүгээ чацуу) тийн ялгалын нөхцөлөөр тэмдэг нэр нь өмнөх үгээ захирна гэжээ.

Ц.Ц.Цыдыпов тэмдгийн нэр өмнөх үгээ дараах тийн ялгалаар захирдгийг буриад хэлний жишээгээр үзүүлжээ. Үүнд,

1. зүрхэндэм урихан, ажилдаа тааруу, зөөрндөө харуу (зөөсөн юмандаа харуу)

2. зангаар хайн, малаар баян, ухаагаар бирагуй

3. донгорогһоо хурса, хадаһаа үндэр, алтанһаа үнэтэй (тонгоргоос хурц)

4. эндээ суутай, үглөөгүүр сэлмэг, ходоодоо налгай

¹⁴ Ц.Өнөрбаян, “Орчин цагийн монгол хэлний үг зүй” МУБИС, МСС., Уб., 2004 230-р т.

¹⁵ П.Бямбасан, Б.Базылхан, Ж.Баянсан, “Үг зүй”, “Орчин цагийн монгол хэл”, ШУА, ХЗХ, Уб., 1997, 246-р т.

¹⁶ Б.Бямбадорж, Орчин цагийн хэлбэр судлал, Ховд их сургууль. НХУС, Уб., 2011, 74-р т.

¹⁷ Цэнгэлтэй, Одоо үеийн монгол хэлний зүй. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1980, 230-р т.

¹⁸ Сунрав.Сэцэн. Үгзүй, “Орчин цагийн монгол хэл”, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1996, 278-р т.

¹⁹ Чойжинжав, Хэлний зүй, “Одоо үеийн монгол хэл”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, Хөх хот 2005. 410-411-р т.

²⁰ Сэцэн, Цогт. Үг зүй, “Орчин цагийн монгол хэл”, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1982, 254-255-р т.

²¹ Тулгуур, Үг зүй, “Орчин цагийн монгол хэл”, Өвөр монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо, 1993, 296-р т.

5. сагаан бор, ехэ үндэр, нарин ута (Өмнөх тэмдэг нэр нь нэрлэхийн тийн ялгалаар хэлбэржжээ гэснийг нь шадарлах буюу хамжих аргаар гол (дараах) үгнээ захирагджээ гэж үзнэ)

6. Ногоон^{ай} ногоон, надтарай набтар, үргэн^{эй} үргэн

7. хара^{аал} хара, гажанхай^{аал} гажанхай, нарин^{аал} нарин²² гэжээ. Үүний 6,7-рх нь тэмдэг нэрийн давуу зэрэг, задлаг аргаар бүтсэнийг, 5-рх нь хоёр тэмдэг нэр нь хамжих аргаар угсран холбогдож, эхний үг нь тодотгол гишүүний байдалтай ажээ. 4-рх жишин үзвэл орон цагийн утгат үгсийг өгөх-орших, үйлдэхийн тийн ялгалаар дараах тэмдэг нэр захирчээ.

Монгол хэлний тийн ялгалын нөхцөлийг орон цагийн ба орон цагийн бус утгатай гэж ерөнхийд нь хоёр ангилж болно. Үүнд²³,

Орон цагийн бус утгат	Орон цагийн утгат
1. Н.т.я.: онгоц- □ нисэв 3.т.я.: үхэр - Ø туулаа	Үй.т.я.: модоор явжээ Сүхээр түлээ хагална Өг.ор.т.я. Чамд өгье, ойд зугаалъя
2. Хам.т.я.: морьтой явна Хүүтэйгээ уулзъя Харь.т.я.: Ахын номыг үзлээ	Гар.т.я.: Хотоос ирээсэй Очоос гал бадарна Чиг.т.я.: Гол руу очъё
3. Жиш.т.я.: Ээж шигээ уран охин байна Ах шиг уургалъя	Х.т.я.: Өвдөгцөө усанд орлоо Дээл шагайн тус шүргэж байна

Тэмдгийн нэр нь орон цагийн утгат үйлдэх, гарах, өгөх-оршихын тийн ялгалаар өмнөх жинхэнэ нэрийг захирах нь зайлшгүй тогтвортой байх ажээ. Үүнд:

- Бардам үгээр цэцэн болдоггүй
Балмад явдлаар баатар болдоггүй
- Дуутай тэнгэр хураар дулимхан
Ууртай амьтан ураар барамхан (В.Ш)
- Залбирсан сэтгэлийн үнэнд
Заяагаар элбэг увдис нь
Залуу модны навчны
Заваа ууланд түгэх шиг
Зээ зүй, зэ хөө, зээ богд лам Махгал минь (Д.Р.)
- Дорно орноо Үзэсгэлэнт гүнж хэмээх нэгэн их хотод шашин ёсыг
сахисан, сан хөрөнгөөр үлэмжхэн Сахилтуу хэмээх нэгэн
баян худалдаачин амьдардаг байжээ. (В.Ш.)
- Малд дургүй хүн гарсаар хашхирна
Галд дургүй хүн очсоор чичнэ

²² Ц.Ц.Цыдыпов Буриад хэлэнэй синтаксис, Бур АССР-эй Гэгээрэлэй министеретво дурадхаба, Улан-Үдэ, 1985, 22-р т.

²³ М.Базаррагчаа. Монгол хэлний өгүүлбэр. Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт, Уб., 1987, 127-р т.

- Даага эхдээ ялдам
Дархан дөшиндөө ялдам
- Дуунд дуртай заан түүний дуунд уяран, нэгэн модны сүүдэрт зөгийн дууг сонсон таг мэлрэн, яг зогсжээ. (В.Ш)
- Төрийн үзэлд хортой
Эзний алдарт халтай
Гоц шорвог үйлийг
Гол тасравч бүү хий. (В.Ш.)
- Сайн худалдаачин хүн гадагш дотогш байнга явж, хямд төсөр зүйлийг олж аваад, ончтой цагт зохистой газар нь өндөр үнээр дамлан гүйлгэх аргад гарамгай байдаг билээ. (В.Ш.)
- Чи надад хайргүй байж л дээ (Д.Батбаяр). Та театрт дургүй бол дургүй л биз (Д.Батбаяр)
- Буруу өссөн хүүхэд
Бухын хүзүүнээс хэцүү
- Маргаашийн өөхнөөс
Өнөөдрийн уушги дээр
- Ингэхлээр хөрөнгө хогшил гэдэг ачит эцгээс ч хүчтэй болох нь. (В.Ш.)
- Тэр газар бол хүн амьтны хөлөөс хол, нүднээс далд, тэгсэн атлаа ус ургамал тэгш, холын бараа харагдах газар байх ёстой гэсэн (С.Э)
- Нөхөр минь, чи бид хоёр төрсөн ах дүүгээс дутуугүй гүн бат барилдлагатай болсон билээ. (В.Ш.)

Жич, тэмдэг нэр нь “-руу, луу” гэсэн нөхцөлөөр илрэх чиглэхийн тийн ялгалаар жинхэнэ нэрийг захирсан нь үйлдэх, өгөх-орших, гарахын тийн ялгал шиг төгс төгөлдөр бүрэлдэж чадахгүй тул “Ургац гол руугаа сайн байна” гэх мэт жишээ ховор юм.

Тэмдэг нэр нь нэрлэх, харьяалах, хамтрах, жишихийн тийн ялгалт жинхэнэ нэрийг захирах нь тогтворгүй хувилбар шинжтэй ажээ. Энэ тухай Чойжинжав, Ц.Өнөрбаян нар дурдсан байдаг билээ.

1. $N_{\text{sub}}^{\text{nomi}} \leftarrow N_{\text{adj}}$. (Ямар ч юмыг гүйцэтгэхийн тулд амь үл хайрлан сэтгэл-шулуун/аар зүтгэдэг бус уу (В.Ш.) гэхэд нэрлэхийн тийн ялгалт “сэтгэл” гэсэн жинхэнэ нэр нь “шулуун” гэсэн хэлбэр заасан тэмдэг нэрнээ захирагджээ. Тэмдэг нэр нь ямагт тодотгох тэг үндсээр жинхэнэ нэр, үйл үгнээ тодотгол гишүүн болдог нь түүний үндсэн ёс юм. Тэгэвч тэмдэг нэр нь үйл үгтэй адил заахаас бусад тийн ялгалт жинхэнэ нэрийг захирах боломжтой бөгөөд ялангуяа нэрлэхийн тийн ялгалт жинхэнэ нэрийг захирах нь үйлшсэн буюу, “бай-, бол-, а-, бү-” үйл үг, тэг холбоц авах боломжтой оршино. Жишээ нь: Эзний зарлиг авсан мөртлөө энэ ч болно, тэр ч болохгүй гэж элдэв шалтаг заан, урагш хойш ажлыг тавих бөгөөд өөд-□ муутай зарцыг ойр байлгахын ч хэрэг юун (В.Ш.) гэхэд нэршсэн, орны утгат тэмдэг нэр нь нэрлэхийн тийн ялгалаар “муутай/байдаг, болсон” гэсэн үйлшсэн тэмдэг нэрнээ захирагджээ. “Заг Байдрагийн хавьцаа халхын өлзий-□ дэлгэр нутагт амьдрал хэвийн голдрилоороо урсан байв (С.Э) гэхэд “Өлзий-□ дэлгэр болсон “нутагт ...” гэж болно. Гэвч нэрлэхийн

тийн ялгалт жинхэнэ нэрийг захирсан тэмдэг нэр нь тэг холбоцоор хэлбэржин үйлшсэн байдаг. Жишээ нь, \Тугал дээрээ тос хуруудыг идүүлсэн

Тус-□ ихтэй-Ø аман хүзүү

Бяруу дээрээ булга торгыг өмсүүлсэн

Буян-□ ихтэй-Ø аман хүзүү (Аман хүзүүний ерөөл)

Хорин “Тогоо-Δ дүүрэн-Ø сүүтэй, Торх-Δ дүүрэн-Ø өрөмтэй бол!” гэхэд “тогоо торх” гэсэн жинхэнэ нэр нь нэг бол, нэрлэх, нөгөө бол, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржиж “дүүрэн-Ø” гэсэн тэмдгийн нэрнээ захирагдсан байна. Ийнхүү нэрлэхийн тийн ялгал нь үйлдэхийн тийн ялгалтай сэлгэж саармагшдаг байна.

Зан-□ сайт, аврал эрдэм-□ төгс чамайгаа санавал, залхуурч холдон, төөрөх сэтгэл төрөх чөлөөгүй үгүй л (Д.Равжаа). Шадар нөхдийнхөө учир-□ төгс үгийг сонсож, Сахилтуу тэндээс түргэн явах нь зүйтэй хэмээн зориг шийджээ (В.Ш.) Тусгал-□ сайтай дуран хурц нүд нь төрсөн газраа энхрий сайхнаар ширтэнэ (Д.Цэвэгмид). Тэд бол угтаа үр үндэсгүй арчигдах заяатай байсан гэвч ялагсдын өршөөл, Далай ламын ивээлээр туурга-□ бүтэн үлдэж, Монгол, Манж, Төвөд гурван улсын завсар хавчуулагдсан, хожмоо ердөө л золиос болохоос цаашгүй амьтас юм санж (С.Эрдэнэ) “гэхэд” “Сайн-Ø зант, төгс-Ø аврал эрдэмт чамайгаа ..., төгс-Ø учиртай үгийг, сайн-Ø тусгалт, бүтэн-Ø туургатай үлдэж ...” гэж байх ёстойгоос байр сэлгэсэн ажээ. Үүнийг, “транспозиция” гэнэ. Ингэж байр сэлгэсэн гишүүн нь өгүүлэхүүн гишүүн өгүүлбэр болсон нь тохиолдоно. Жишээ нь:

Үртэй хүн-□ өвөр-□ нойтон Ø

Үргүй хүн-□ нүд-□ нойтон Ø

2. $N_{\text{sub}}^{\text{nomi}} \leftarrow N_{\text{adj}}$. “Хун шиг цагаан, дун шиг хатуу, хуйгүй хурдан, салхигүй сайхан болтугай” гэхэд “цагаан, хатуу” гэсэн өнгө чанар заасан утгатай тэмдэг нэр нь “шиг” гэсэн жишихийн тийн ялгалаар “эсгий”-ний өнгө чанарыг “хун, дун”-ийн өнгө чанартай адилтгасан ажээ.

Жишихийн тийн ялгалаар жишин харьцуулж буй хоёр юмын адил шинжийг илтгэх тэмдгийн нэр нь “дун шиг цагаан, дурдан шиг артай” гэхэд “эсгийний цагаан өнгийг дунгийн цагаан өнгөтэй, мөн эсгийний арын хатууг дурдангийн арын хатуутай тус тус адилтгасан байна. Гэтэл адилтгасан тэмдгийн нэрийг нь орхиж, эсгийний бөх шинжийг “бухын магнай, азарганы саарь мэт болтугай!” гэж адилтгасан байна. Түүнээс гадна, “яснаас хатуу, цаснаас цагаан” гэж ясны хатуу, цасны цагаан шинжээс давуулан адилтгасан байдаг.

Мөн адилтган харьцуулж буй зүйлийн хир хэмжээг заахдаа тэмдгийн нэрийг далдалсан байх ба адилтгасан холбоосыг “чинээ” гэсэн жинхэнэ нэрээр тодосгон орлуулжээ.

Дэлхийн чинээ дэвжээтэй бол, уулын чинээ унгастай бол! гэж ихэсгэсэн хэтрүүлгээр хэлжээ. Тэр ч байтугай шинж чанар заасан тэмдгийн нэр, адилтгасан холбоос хоёрын аль алины нь орхин, саваа нь шандас, унгас нь мяндас” гэжээ.


Хар хорумд буюу их хааны ордонд Цотон шиг уран дархан хүн хэрэгтэй Чормогон мэдээд бас ч золиосонд авахад илүү таарах хүн үгүй гэж шийдээд явуулсан биз (С.Эрдэнэ)

- Гаднаас нь харвал согоо шиг гоё

Дотроос нь үзвэл, могой шиг хортой

- Элгэн хад өөд
Төлгөн хуц мөргөнө
- Ямаан сэгэн дээр
Тэмээн чинээ буг болох.

Эдгээр жишээний эхнийх нь Цотон хүн хоёрыг урнаар нь адилтгасан бол 2-рх нь хүний гадаад дотоод шинжийг согоо могойтой “гоё, хортой” шинжээр харьцуулахдаа адилтгагдахууныг далд орхижээ. 4-рх жишээнээ дээр өгүүлсэн тэмдэг нэр (их буюу том)-ийг орхижээ. 3-р жишээ нь хадны толигор цул шинжийг амьтны цул хүрэн шинжтэй харьцуулахдаа шинж заасан тэмдэг нэр, “шиг, мэт” зэрэг холбоосыг гэж, шууд, “элгэн хад” гэж адилтгасан байна. Адилтгасан харьцууллыг




гэсэн байдалтай болно.

Өвлийн шөнө тэнгэрийн одод оч мэт гялалзахад

Удам талд жинчин хүний дуулах яруу (Д.Н) гэхэд, “одод” нь адилтгагдахуун, “оч” нь адилтгахуун болсон ба шинж чанар нь “гялалзах” гэсэн үйл үг болох, эсвэл “хурц, тод, яруу” гэх мэт тэмдгийн нэрийг орхисон байж болно. Үүнд “мэт” гэсэн адилтгасан холбоосыг ашиглажээ.

Тэгвэл дээрх загварт бүрэн тохирох жишээ гэвэл “Тэрхүү толь шиг тунгалаг, цас мэт цагаан саран дүв дүгрэгээр манай хажууд гэрэлтэж, идэр залуу зохиолчдын оюун ухаанд гэгээн туяагаа тусгана (Д.Н) гэсэн өгүүлбэр байна. Үүнд,



Харин “Саран манай хажууд гэрэлтэж, зохиолчдын оюун ухаанд гэгээн туяагаа тусгана” гэхэд “Сар”-ыг амьдчилан хүншүүлсэн нь далд адилтгал болох ба үүнийг “оюунт хүн мэт саран” гэж дэлгэрүүлж болно.

Царайн өнгө арчсан толь мэт

Цав цагаан шүд яралзаж, өдийн хөмсөг зурайна

Харах нүдний хар цагаан хосолж

Хас чулуунд шигтгэсэн лүнтэн мэт” (Д.Н) гэхэд шинж чанар заасан тэмдэг нэрийг орхисон ба “өдийн хөмсөг” гэхийг “өд мэт жирвэгэр / жирвийсэн (нарийн) хөмсөг”, эсвэл “өдийн адил зургар хөмсөг” гэж дэлгэрүүлж болно.

“Ялгам сайхан сар минь ертөнц дэлхийн дэнлүү, Янаг амраг хүү минь ямагт миний дэнлүү (Д.Н) адилтгах холбоос, тэмдэг нэр хоёрыг орхиж, зөвхөн “сар дэнлүү, хүү дэнлүү” гэж хоёр жинхэнэ нэрийг өгүүлэгдэхүүн өгүүлэхүүний харилцан угсрах харьцаанд тавьж, адилтгасан байна. “Шинэ эмнэлэг бол илд,

толь, нөхөр” (Шинэ эмнэлэг) гэж, тэмдэг нэр, холбоос хоёрыг орхиж хураасан адилтгал нь “Шинжлэх ухаан бол илд, толь, нөхөр” (Шинжлэх ухаан) гэсэн шүлгээс эхтэй хувилбар юм. Үүнд,

Бодисын ёсны шинжлэх ухаан бол

Бурангуй ёсыг эвдэгч илд

Бүдүүлэг байдлыг гэгээрүүлсэн толь

Бүх хүн төрөлхтний нөхөр юм

Бодисын ёсны шинэ эмнэлэг бол

Бузар өвчнийг цавчих илд

Бүдүүлэг байдлыг гэгээрүүлэх толь

Бүх хүн төрөлхтний нөхөр юм

Энэ тухай Д.Отгонсүрэн “Энд зүйрлэлийг (адилтгал М.Б.) нэг бадагт гурван мөр дараалан бие даасан өгүүлбэрт багтаан оруулахдаа зүйрлэсэн үгээ хэлний зүйн нэр өгүүлэхүүн болгосон нэгж өвөрмөц онцлог байгаа бөгөөд ингэснээр ч баталж нотолсон аяс тодорхой илэрдэг байна”²⁴ гэж тэмдэглэжээ. Тэрээр, тэмдэг нэр, холбоосыг гэсэн хураангуй адилтгалыг зүйрлэл гэж үзсэн байна²⁵. Жишээ нь: Ясан уул, босож, цусан далай урсаж ...” гэсэн адилтгалыг зүйрлэл гэсэн ба үүнийг дэлгэрүүлбэл овоолсон яс мэт хувхай уул босож, цус мэт улаан далай урсаж ...” гэж болно.

“Өрхөн дээр өөхөн цөвдөл” гэсэн монгол ардын оньсогонд адилтгахуунаар адилтгагдахууныг таалгах гэж оньсоголсноос үзвэл, “Өөхөн цөвдөл шиг од” өрхөн дээр байна” гэсэн өгүүлбэр болно. Үүнд, “од” гэсэн адилтгагдахуун “шиг” гэсэн холбоос хоёрыг орхин оньсголсон бол “өөх” гэсэн жинхэнэ нэр нь уг юмын бүтсэн эд болохыг заах авч, “цагаан” гэсэн үгээ гээжээ. Иймээс “өөх мэт цагаан цөвдөл” гэсэн дэлгэрэнгүй адилтгасан холбоо үг байжээ. Үүнчлэн “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү тэгж эрдэнэ өвөртөлж харина (Д.Н) гэхэд “эрдэнэ” гэсэн адилтгахуун нь “мэт, эрдэм” гэсэн холбоос, адилтгагдахууныг орхин хэлсэн ажээ. “Иргийн гүзээ үсгүй, сэрхийн гүзээ үстэй” гэхэд адилтгагдахуун (тэнгэр, газар), холбоос (гүзээ шиг үсгүй) хоёрыг далдалсан байна.

Б.Ринчен гуайн “Сар” хэмээх шүлэгт буй адилтгал буюу $N_{\text{sub}}^{\text{comp}} \leftarrow N_{\text{adj}}$ загвар бүхий холбоо үгийг үзье.

Цоохор шар саран чавганц – чавганц мэт цоохор шар саран

Цоорхой үүлэн дээлээ хэдрээд – цоорхой үүл мэт цоорхой дээлээ хэдрээд,

Туяан цагаан таягаа тулаад – туяа мэт цагаан таягаа тулаад,

Тугал олон одон сүргээ туув – одон мэт олон сүрэг тугалаа туув

Үүлэн цоорхой дээлий нь ноолон – үүл мэт ноорхой дээлий нь ноолон

Үеэл хөвүүн салхи үлээн наадав – салхи мэт үеэл хөвүүн наадав

(1927.VIII.30)

гэж хувиргавал сая “цоохор шар, цоорхой, цагаан, олон, ноорхой” гэсэн тэмдгийн нэр нь “мэт” хэмээх холбоосоор “чавганц, үүл, туяа, од, үүл” зэрэг жинхэнэ

²⁴ Д.Отгонсүрэн Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулга, уран сайхны онцлог. Улсын хэвлэлийн газар, Уб., 1984, 27-р т.

²⁵ Д.Отгонсүрэн, Дурдсан зохиол. 28-29-р т.

нэрийг тус тус захирсан ба сүүлчийн мөрнөө “дэггүй, саваагүй, эрх танхи” гэх мэт тэмдэг нэрийг гээн хураажээ. Мөн “Нева мөрөн” (ленинград. европ буудал, 1947.vii.9) шүлэгт дээрх загварын дагуу холбоо үгийн тэмдэг нэр нь үйл үгийн өмнө гээгдэх нь олонтоо тохиолдох бөгөөд энэ нь тухайн үйл үг нь тэмдэг нэр шиг уул юмсын шинж чанарыг заадагтай холбоотой юм. Үүнд:

Шингэх нарны туяанд Нева мөрөн
 Эртний үлгэрийн Балбын дархан балбасан
 Шидэт баатрын юлд мэт гялалзан харагдам
 Эргийн боржин чулуун хүйд шургуулан хийсэн
 Ширээж давтсан болд юлдийн адил, усны мяралзах нь
 Эртний домгийн дархны лантууны ор шиг санагдам

Өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэрийн тэмдэг нэрээр бүтсэн төгс өгүүлэхүүний бүрэлдэхүүнд энэ адилтгасан холбоо үг багтан орох нь цөөн биш юм. Жишээ нь:

Тийнхүү таван жилийн турш алтан нутаг, амраг садангаа мөрөөдөн, биеэ золиосонд барьж өгсөн хугацааг яаж баръя гэж байтал сураг ажиг дуулдах-□ нь өдрийн од мэт ховор (С.Эрдэнэ). Үүнчлэн энгийн өгүүлбэрийн өгүүлэхүүн ч ийм загвараар бүтдэг. Жишээ нь,

Ээ, тэнгэр минь хорвоо гэдэг хуурамч бус уу. Залуу нас гэдэг уулын горхи шиг түргэн бус уу? (В.Шармаа): Амьдрал гэдэг өвсний гал шиг дүрэлзсэн түргэн бус уу? (В.Ш)

3. $N_{sub}^{T_{sub}^{GENE}} \leftarrow N_{adj}$ Жинхэнэ нэрнээ хамжин тодотгож орсон тэмдгийн нэр нь үйл өгүүлэхүүний байрнаа шилжин тонгорохдоо тодотгож байсан жинхэнэ нэрээ харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр хэлбэржүүлдэг. Жишээ нь:

- Ган болоход булаг-(ийн) сайн \emptyset мэдэгдэх,
 Гай болоход нөхөр-ийн сайн \emptyset танигдах
- Эрдэм-ийн дээд \emptyset эв
- Эрхэм-ийн дээд \emptyset эх
- Мэх-ийн их \emptyset үнэгэнд
 Мэнд-ийн их \emptyset бялдуучид
- Найр-ын богино сайн
 Нас-н-ы урт сайн
- Төмөр-ийн сайн зэвэрдэггүй
 Төрөл-ийн сайн мартагддаггүй

Ингэж тэмдгийн нэрийн байр шилжсэнээр өгүүлбэрийн хувиргал бүтээж буй чинагуун бүтэц буюу хэлэгдэхүүнээс инагуун бүтэц буюу хэлэхүүнийг бүтээж буй хэрэг болно.

- Тэндхийн өвс ногоон-ы шимтэй, үр жимс/н/ий арвиныг хэлээд барах юм биш (В.Шармаа)

- Огцорсон эцгийнхээ өшийг авч, огцруулсан арсланг чадан бүрэлгэх муу санаа агуулан цаг-ийн аятайг отон, тэр хоёр, арслангийн хамт үргэлжид цуг явдаг байжээ.

- Гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн харьяалах, заахын тийн ялгалын алинаар нь хэлбэржих тухай Ш.Лувсанвандан гуай "энэ мэтээр үйлт нэр

өгүүлэхүүн бүхий гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэртээ өгүүлэгдэхүүн тодотголын үүргийг гүйцэтгэхдээ нэрийн утгаар үйлчлэх тул мөнхүү гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нь харьяалахын тийн ялгалаар хэлбэржих нь зүйн хэрэг" юм. Харин үйлт нэр өгүүлэхүүн бүхий гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэртээ байц гишүүний үүрэг гүйцэтгэхдээ голдуу үйлийн утгаар үйлчлэх тул мөнхүү гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нь гол төлөв заахын тийн ялгалаар хэлбэржих ажээ. Жишээлбэл: -Би таны зурснаар зурна. Би таныг зураг зурахлаар зурна,²⁶ гэж ялгасан шиг дээрх гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нь харьяалахын тийн ялгалаар хэлбэржиж буйг уул гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь тэмдгийн нэрээр илэрч байгаагаар тайлбарлаж болох ажээ. Харин

- Ган болоход булгийн (сайн) чанар мэдэгдэх

Гай болоход нөхрийн (сайн) чанар танигдах" гэвэл "булаг-ийн чанар, нөхөр-ийн чанар" гэж хоёр жинхэнэ нэр харьяалахын тийн ялгалаар холбогдох нь зүйн доторх хэрэг болно. "Эцэг эхээс заяатай эрдэнийн алтан өлгий минь (Ж.Баяраа) гэхэд "алт шиг үнэ цэнэтэй өлгий гэж анхдагчийг сэргээж болох ба "эрдэнийн өлгий" гэвэл эрдэнэ мэт нандин өлгий гэж сэргээж болно. Иймд харьяалахын тийн ялгал нь тохиолдолд "мэт, шиг, адил" гэх мэт холбохын үүргээр ордог ажээ. Ийм жишээг үзүүлбэл:

- Усан болрын өнгөтэй урт сайхан Хэрлэн минь

Урсах сайхан долгиондоо уран хуурын эгшигтэй (Ц.Д)

- Алаг цэцгийн (гоёмсог) хөнжилтэй

Алтан эрдэнийн (ариун) хэвэлтэй

Ариун шимийн (арвин) хөрстэй

Атар хээр нутаг минь (Ц.Д) гэхэд харьяалахын тийн ялгалт үг нь адилтгах утга бүхий "шиг, мэт" хэмээх холбоосын утга үүргээр орсон байж болох ба харьцангуй тэмдгийн нэр (Хөнжилтэй, хэвэлтэй, хөрстэй)-нээ захирагджээ. (Жич улам тодорхой болгохын үүднээс "жинхэнэ" тэмдгийн нэрийг завсар нь хавчуулсан болно). Ингэж жишихийн тийн ялгалаар тэмдэг нэрнээ захирагдах нь хааяа харьяалахын тийн ялгалтай сэлгэдэг байна. Энэ тухай эрдэнийн өлгий (эрдэнэ мэт өлгий), зандангийн үнэр (зандан шиг үнэртэй), уушгины зүстэй (уушги шиг зүстэй) гэх мэт жишээнээс харьяалахын тийн ялгал нь адилтган жиших утга илтгэдэг хэмээн үзсэн байна²⁷. Энэ тухайд ... хасын өнгөт дөрвөлжин цагаан шүдээ яралзуулан, үе үе инээмсэглэн мишээх хаврын улирал ирж буй адил бахтай. (Д.Н). Нэгэн бүлэг сувдын аялгууг арайхан ойлгож өнгөрүүлэвч дараагаар бас нэгэн сүрэг цэцэгсийн хөг айлчлан ирэх тул.. (Д.Н) Ногоорон харагдах уул нь номин эрдэнийн уул аа (Д.Н) гэх мэт жишээ татсан байна. Хасын сайхан гэрэлд чин хайртай хүү минь харагдах шиг. (Д.Н)

Жавхлант эрийн хурдан жороо хүлгийн эрхшээл Уянгат утгын амт-ын сайханд шингэж оршиж... (Г.Сэр-од) гэсэн жишээ татаж болно.

4. $N_{\text{sub}}^{\text{com}} \leftarrow N_{\text{adj}}$

²⁶ Ш.Лувсанвандан, Монгол хэлний нийлмэл өгүүлбэрийн тухай асуудалд, Багш сэтгүүл №3. 1957, 10-р т.

²⁷ М.Базаррагчаа Харьяалахын тийн ялгалын утгыг ангилах нь, Эрдэм шинжилгээний бичиг, МУИС, МСДС, 13-р боть, 72-р т., Монгол хэлний өгүүлбэр судлал, УБ, 2005, 144-195-р т.,

Удалгүй хүрээний наймаа хотын бараа харагдаж, байдал нь Бээжингийн барилгатай төстэй (Б.Ринчен), Түүний доторх уул ус үнэхээр гайхамшигтай сайхан. (Д.Н) (Жич, “гайхамшигтай” гэдэг нэгэнт тэмдгийн нэр болжээ)

Ертөнцийн зохицол, байгалийн бүтээлт юутай сайхан. (Д.Н) Сэтгэл зүрхний хүү минь шимтэй халуун янаглалтай. (Д.Н). Зүүн Европын газрын байдал Сибирийн хязгаартай төлөв ойролцоо бөгөөд ... (Д.Н) гэсэн жишээний “барилгатай, төстэй, хязгаартай, ойролцоо” хэмээх нь хамтрахын тийн ялгалт жинхэнэ нэрийг зохих тэмдгийн нэрээр захирсан ба үүнээс бусад "гайхамшигтай, юутай, шимтэй" гэсэн үгийн "-тэй" бүтээвэр нь харьцангуй тэмдэг нэрийн шинжтэй болж, арын тэмдэг нэртэй хоршин, эсвэл давуу зэргийг илтгэх угтвар бүтээврийн үүргийг гүйцэтгэх мэт болсон байна. Энэхүү "-тай"⁴ бүтээвэр нь ардаа хамаатуулах нөхцөлийг “Баясгалан ахтайгаа адилхан. Баян хүн худалдаачинтай нь янаг. Бааран хүн нохойтой нь янаг, Бялдууч хүн ноёнтойгоо янаг” гэх мэтээр тэмдгийн нэр нь өмнөх жинхэнэ нэрээ хамтрахын тийн ялгалаар захирч буйн гэрч болдог. Иймээс гайхамшигтай -(г)аа сайхан, юутай (минь) сайхан, шимтэй(г)ээ халуун гэж хэлэлцэхүй тул энэ "-тай" нь хамтрахын тийн ялгалт биш юм. Бичгийн хэлнээ холбох тийн ялгалаар тэмдгийн нэр нь өмнөх жинхэнэ нэрийг захирах нь мэр сэр тохиолдож байна. Тухайлбал, ... nidün inu sibaγün metü dour-a-aça degēgsi aniqu: laγsin belges-lügē tegülder nigen köbegün törügßen-dur ... (Эрдэнийн товч. 121-р т.), burqan-luyā ilγal-ügei adalīqan (Эрдэнийн товч. 120-р т.), dörben yeke degēdüs-lügē tegülder (Эрдэнийн товч. 129-р т.), tere Temüjin-lüge nigen eketei: qasar, qačigin, očigin dörben köbegüd (Эрдэнийн товч. 133-р т.)²⁸, Yisügei bayatur-luyā anda kemeldügßen ajuγu (АТ. I, стр. 119), Yeke aγya küčün-lüge çoγtu törügßen ... Boyda Činggis qaγan minu (АТ. II, стр. 11), Qad-luyā sačaju bui kemen ... (АТ. II, стр. 58)²⁹, küjügün-ēce tan-u tataju kümün-lügē sačaju bolγaju, eγem-ece tanu tataju ere-lüge sačaju bolγaju... (Altan tobči, p. 48-49)³⁰ г.м.

Эд бүгдээс үзвэл, үйлдэх, өгөх орших, гарахын тийн ялгалаар жинхэнэ нэрийг захирсан тэмдэг нэр бүхий холбоо үг нь зайлшгүй тогтворт шинжтэй бол, нэрлэх, хамтрах, жишихийн тийн ялгалаар захирвал тогтворгүй хувилбар бүхий шинжтэй юм. Тухайлбал:

Унаган хээр нь хазаар даран тэмүүлэхэд унасан эзэн нь санаа-□ дүүрэн баяртай, гэхэд "санаа" гэсэн нэрлэхийн тийн ялгалт жинхэнэ нэр нь "санаа-(г)-аар" гэж үйлдэхийн т.я-аар сэлгэж болно. Энэ мэтээр дээрх загвар бүхий холбоо үгс нь хоорондоо сэлгэж болно. Үүнд,

1. - Тал бүрийн салаа жалгаар	Тал бүрийн салаа жалга-□ нь
Таван эрдэнийн баялаг сүрэгтэй	Таван эрдэнэ мэт баялаг сүрэгтэй
- Өвс ундаар элбэг дэлбэг	Өвс унд-□ элбэг дэлбэг
Он тарган хэвээр ороход...	Он тарган хэвээр ороход
- Ташуугаар дүүрэн	Ташуу нь дүүрэн

²⁸ Qad-un üндүсүн-ü erdeni-yin tobči, Эх бичгийн цогц судалгаа хийсэн М.Баярсайхан, Уб., 2011, 121, 129, 133-р т.

²⁹ М.Н.Орловская, Язык “Алтан тобчи”, Издательство “Наука”, М., 1984, стр. 50

³⁰ Hans-Peter Vieve, Gendeng Lubsang: Altan tobči, text and index, Tokyo, 1992. P.48-49

- | | |
|---|--|
| <p>Тавин улаан тэмээнээс
Тавьхан лангийн үнэтэй
Миний ээж хаачив (<i>Өнчин цагаан ботго</i>)
- Эргүүлээд боосон <u>үс чинь</u>
Эрээн лууны <u>эвэр адилхан</u> (<i>Сүнжидмаа</i>)
Нүүдлийн хойноос ажихад
Нүдээр <u>дүүрэн</u> нулимстай (<i>Жаахан шарга</i>)
- Амраг гэдэг нь хэцүү юм.
Алчуур-□ <u>дүүрэн</u> нулимстай
(<i>Амттай алим</i>)
Үлэмжийн <u>чанар</u>- □ <u>төгөлдөр</u>
Өнгө-□ <u>тунамал</u> толь шиг хө хө
(<i>Үлэмжийн чанар</i>)
Эвэр сүүл-□ <u>тэнцүүхэн</u> төрсөн
Эзэндээ <u>ээлтэй</u> үхэр хоёр жил
(<i>Арван хоёр жил</i>)
2. Тодхон харагдах өндөр Алтай
Толь <u>шиг мөнгөн</u> цастай даа
(<i>Цацал</i>)
3. Булгийн ус <u>мэт тунгалаг</u>
Бургасны мөчир <u>мэт шулуун</u>
Буянтай таныгаа гэж ирлээ
(<i>Хантарган</i>)
4. Үргүй хүн нүд-□ <u>нойтон</u>
Үртэй хүн өвөр-□ <u>нойтон</u>
5. Тэнгэртэй <u>адилхан</u> хүн байдаг
Далай шиг хүн ...
Сартай адилхан хүн байдаг
Санаа алдалт шиг (Л.Ө)
6. Салхинаас <u>өөр</u> эзэнгүй, өвснөөс <u>өөр</u> туяагүй
Саруул нам гүм танд эцгийн минь булш бий. (Л.Ө)</p> | <p>Тавин улаан тэмээнээс
Тавьхан лангийн үнэтэй
Миний ээж хаачив.
Эргүүлээд боосон үс чинь
Эрээн лууны <u>эвэртэй адилхан</u>
Нүүдлийн хойноос ажихад
Нүд-□ <u>дүүрэн</u> нулимстай
Амраг гэдэг нь хэцүү юм.
Алчуураар <u>дүүрэн</u> нулимстай хө.
Үлэмжийн чанараар төгөлдөр
Өнгөөр <u>тунамал</u> толь шиг хө хө.
Эвэр сүүл-ээрээ <u>тэнцүүхэн</u> төрсөн
Эзэндээ <u>ээлтэй</u> үхэр хоёр жил.
Тодхон харагдах өндөр Алтай
Тольтой <u>мөнгөн</u> цастай даа
Булгийн уснаас <u>тунгалаг</u>
Бургасны мөчрөөс <u>шулуун</u>
Буянтай таныгаа гэж ирлээ.
Үргүй хүн нүдэндээ <u>нойтон</u>
Үртэй хүн өвөртөө <u>нойтон</u>
- <u>Тэнгэр хүн</u> байдаг
Далай шиг хүн ...
Саран хүн байдаг
Санаа алдалт шиг</p> |
|---|--|

Ийнхүү тэмдгийн нэрнээ тийн ялгалт жинхэнэ нэр захирагдах ёсыг тогтвортой тогтворгүй гэж ялгаж болно. Үүнд:

<i>Тогтворгүй хувилах</i>	<i>Тогтвортой хувилах</i>
1. $N_{sub}^{nomi} \leftarrow N_{adj}$	$N_{sub}^{instr.} \leftarrow N_{adj}$ Газар үндсээр <u>баян</u> , Тэнгэр одоор <u>баян</u> , Далай усаар <u>баян</u>
2. $N_{sub}^{comi} \leftarrow N_{adj}$	$N_{sub}^{dat-loc} \leftarrow N_{adj}$ Эрдэнд алт нэг <u>шар</u> , Эдэнд жанч нэг <u>шар</u> , Идэнд уураг нэг <u>шар</u> .
3. $N_{sub}^{comp} \leftarrow N_{adj}$	$N_{sub} \leftarrow N_{adj}$ Тостойгоос тогоо <u>хар</u> . Билигтэйгээс бэх <u>хар</u> , Амттангаас архи <u>хар</u> .

Цагт нэр нь тэмдгийн нэртэй адилаар ямагт жинхэнэ нэрнээ хамжих тодотгол гишүүн өгүүлбэр болно. Тэгэхдээ тэмдгийн нэр нь нэр ба үйлийн өмнө хамжсан тодотгол гишүүн болдог. Гэвч хэлэхүүний түвшинд цагт нэр нь

арын жинхэнэ нэрээ гэж, тийн ялгалын нөхцөлөөр хувилж, тэмдгийн нэрнээ захирагдана. Жишээ нь:

1. $U_{\text{part.}}^{\text{comi.}}$ - Тарган цатгалан явах нь байтугай турж үхэхгүй яваа-□ маань их юм. (В.Ш)

- Туйлбаргүй хүн буцах-□ нь амар

Тугалган жал шантрах-□ нь амар

- Халх Ойродын өс хонзон арилав гэсэн-□ чинь аль вэ? (С.Э)

- Тэгэхдээ энэ ийм амар хэрэг биш гэдэг-□ нь үнэн. (В.Ш)

- Гэтэл тэр уйлж унжсан байгаа биш, айн цочсон ч хэрэг биш, ердөө л бие алдран, эмгэг өвчин туссан хүн шиг болсон-□ нь илт. (С.Э)

2. $U_{\text{part.}}^{\text{comi.}}$ - Та бид хоёрын найз нөхөр болно гэдэг гал хуурай өвс хоёрыг нэг дор агуулах гэсэнтэй адил үл тохирох зүйл мөн бус уу. (В.Ш) Одоо Миларабын дүрийг бүтээсэнтэй чинь адил хүн төрхдөө ойр нь дээр гэж хэлж байсан. Дисрэд тэргүүтэй Миларабын дүрийн Их зуугаас зайлуулах гэхэд одоо цагийн бурхан хүн дүрээрээ байх-□ нь дээр. (С.Э) Тэнгэртэй адилхан хүн байдаг. Далай шиг хүн... Сартай адилхан хүн байдаг, санаа алдалт шиг. (*Л.Өлзийтөгс*)

3. $U_{\text{part.}}^{\text{comp.}}$ Та нарыг тус болно гэж бодож суух шиг дэмий юм хаа байх билээ. (В.Ш) Тэдний дотроос панз шуугиулж, хожоо гаргах шиг олзтой омогтой ая зан байдаггүй.

4. $U_{\text{part.}}^{\text{instr.}}$ Малгай буулгахгүйгээр дулаан. Магнай жиндэхгүйгээр бүлээхэн... (*Алтай хайлах*)

5. $U_{\text{part.}}^{\text{dat.-loc.}}$ - Тэгээд энэ бүхнийгээ Ханд яах гэж буйг нь харин мэдэхэд хэцүү. (С.Э) Салхитай тэнгэр цэлмэхдээ түргэн. Сүржигнүүр тэнэг няцахдаа товчхон (В.Ш)

- Учир иймд хөрөнгө баялаг хураахад наймаанаас өөр сайхан зам байхгүй (В.Ш)
- $V_{\text{part.}}^{\text{alla.}}$ - Тоглохоос өөр юмгүй долоон нас, наадахаас өөр юмгүй найман нас
- Нөхрийн чинь хэргийн төлөө зүтгэх минь чиний төлөө зүтгэхээс ч илүү хүндтэй хэрэг билээ. (В.Ш)
- Үүний хувь зохиолд идэх уух, өмсөх зүүхээс илүү юм бичигдэхгүйг мэдэхгүй гэж үү (В.Ш)
- Харангадаж үхсэнд орвол хатсан ганц хоёр буурцаг түүн, амиа зогоохоос өөр арга алга. (В.Ш)
- Бошигтын хэлснээс бүх юм илхэн байна. (С.Э)
- Өнчдөд тусалъя гэснээс ач үрээ бодсон чинь дээргүй юу? (В.Ш)
- Иймээс эмийг гомтгоно гэдэг эзнийг гомтгосноос хэцүү ланчигтай хэрэг буюу (В.Ш)
- Цамбагарав, Алтайн даваанд болсон мөргөлдөөний дараа үүнийг гэв гэнэт ухаараад, туйлгүй бухимдахдаа хэрвээ хэрэг явдал муугаар эргэвэл Чахунханд биеэ тушааж, барьцаанд явахаас өөр замгүй болно гэж бодож явлаа. (С.Э)
- Олсноос хэрэгтэй хүний бие, санаснаас хэрэгтэй буяны шүтлэг. (Д.Равжаа)

- Энэ нүгэлт орчлонд эрх дураараа явж, олдсон насыг өнгөрөөхөөс илүү сайхан юм хаа байна. (С.Э) Инээхээс өөр яах вэ? /юу хийх вэ?/ юм ч алга.

Эдгээрээс гадна, тэмдгийн нэр нь тийн ялгалаар хуурмаг хувилах нь бий.

Жишээ нь:

1. N_{adj}^{nom}
 1. Зодохын муу-□ чимхэх, ярихын муу-□ шивнэх
Саяхны баян-□ сайрхуу, Угийн баян-□ омгорхуу.
Төмрийн сайн-□ нь зэвэрдэггүй,
Төрлийн сайн-□ нь мартагддаггүй
 2. Үүдээ даахын чадалгүй, үгээ хэлэх-ийн чимээгүй өвгөн болж...
(Алтай хайлах) (даах чадалгүй, хэлэх чимээгүй гэж цагт нэр нь өөрийн үүргээрээ буюу хамжсан тодотгол болох боловч онцлон ялгахын үүднээс харьяалахын тийн ялгалыг хэрэглэдэг нь сонин юм).

Гурван жилийн хол газар гучин хоёр зурхайч байгаа. (Алтай хайлах)

2. N_{adj}^{accit} Огцорсон эцгийнхээ өшийг авч огцруулсан арсланг чадан бүрэлгэх муу санаа агуулан, цагийн аятайг отон, тэр хоёр арслангийн хамт үргэлжид цуг явдаг байжээ. (В.Ш)

Согоо саарлыг сургаж болдоггүй, Сухай ташуурыг барьж болдоггүй. (Чоно, могой)

Энэ хуурамч хорвоод чам шиг бусдын сайныг бодож явдаг амьтан хаа байна? (В.Ш)

Их мөрнийг далан хаалгаар тогтоох хэцүүгийн адил хаан төрийн хишгийг тогтоон хүртэхэд зовлонгийн ихийг амсдаг ажээ. (В.Ш)

Төмрийн сайныг дархан мэддэг. Төрийн сайныг өвгөд мэддэг.

Зарим нэг эзэн хаад ухах ухаан- □ мөхсийн хар гайгаар дээд тушаалд зохих сайн хүнээ доод тушаалд байлгадаг бөгөөд цаадах нь ч тэр дороо авьяас чадлаа үрэн сууж байдаг. (В.Ш)

3. N_{adj}^{genc} - Хад сайтын үнэг бардам, Хадам сайтын хүргэн бардам, Ноён сайтын албат бардам, Нохой сайтын хот бардам.

Харцны үзүүрт, салхины үзүүрт, харанхуйн үзүүрт, хаана ч алга (Л.Өлзийтөгс)

4. N_{adj}^{comi} - Сайнтай нөхөрлөвөл сарны гэрэл,
Муутай нөхөрлөвөл могойн хорлол
Сайнтай бүү мэлз, Муутай бүү болз
Урантай утас битгий булаалд, Ухаанттай үг битгий булаалд

5. N_{adj}^{instr} - Энэ үхэл хэмээвэл, олз эдийн ихээр зальт болдоггүй, аргын сайнаар хоног цагийг хойшлуулж болдоггүй, омог хүчний ихээр эсрэглэж гарч болдоггүй. (В.Ш)

Дайсан хараад, бөхийн унаж айхын ихээр шалчийн дордож үхсэн муу эрийн тамтгийг лаван хүүхэлдэй гэлтэй. (В.Ш)

...Өнтэй тарган мал сүргийн өөх нь дөрүү (дөрвөн хуруу) зузаанаар тогтож. (Алтай хайлах)

Жаргахын ихээр жаргаж жаран тав хоноод

Найрлахын ихээр найрлаж наян тав хонолоо. (Алтай хайлах)

6. N^{dat-loc}_{adj}

- Нүдээ нээвэл харанхуйд.. сарын гэгээнд анивчихгүй зүсээ тольдолгүй уджээ. (Л.Өлзийтөгс)

- Замаг сайтад загас болгон цугладаг, Зан сайтад хүн болгон цугладаг

- Төмрийг халуунд нь давт. Гэтэл тэрвээр хуудам авьяас, шуналын ухаан, засдаг хуурамч зангаас цаашгүй нэгэн болох нь олонд бас илэрхий (С.Э)

7. N^{abl}_{adj} - Хэнээс ч баян болохын тулд бузраас ч бузар ажил үйлдэж, адгаас ч адаг амьтанд ойртож, оршоох газрын ч хишиг хайдаг. (В.Ш)

Гучин хэдхэн настай монгол эр ингэж хийморио сэргээгээд явахаараа усны урт, газрын холоос яахан шантарна. (С.Э) Өндрөөс мөндөр бууна. (Тэмээний хоргол)

8. N^{comp}_{adj} - Хурган хонины ноосоор хуруу зузаан зулан хийсэн, (хуруу шиг зузаанаар) Төлгөн хонины ноосоор төө зузаан зулан хийсэн, (төө шиг зузааныг)

Хөвөө болсон цагаан тохмы нь

Хөтөл болсон уужим нуруунд нь тавиад... (Алтай хайлах)

Өөхөн бөмбий, араг сэгсий (хонь) (өөх шиг бөмбий, араг шиг сэгсий)


Ийнхүү тэмдгийн нэр нь³¹ цагт нэртэй адилаар жинхэнэ нэрийн нөхцөлөөр үл хувилах ба цагт нэрийг бодвол жинхэнэ нэр ба үйл үгийн өмнө хамжин орж тодотгол гишүүн болдог. Харин хэлэхүүний хувьд, тэмдэг нэр, цагт нэр нь жинхэнэ нэрийн хувиллаар чөлөөтэй хувилна. Тэмдгийн нэр нь заахаас бусад тийн ялгалын нөхцөлөөр өмнөх жинхэнэ нэрийг захирдгаараа үйл үгтэй төстэй юм. Ийнхүү хоёр үгийн нэг нь нөгөөгөө хамжих болон найрах аргаар захирдаг нь зарим эрдэмтдийн зүйрлэн хэлдэгчлэн, эзэн зарц- ын харьцаатай байдаг ажээ.

Жинхэнэ нэр нь өмнөх жинхэнэ нэрээ зөвхөн харьяалах, жишихийн тийн ялгалаар захирдаг бол жинхэнэ нэр нь харьяалахаас бусад тийн ялгалаар үйл үгнээ захирагдана. Харин жинхэнэ нэрнээ тоо ба тэмдгийн нэр, цагт нэр нэр хамжин захирагддаг. Үүнээс үзвэл, цагт нэр нь нэг талаар, тоо ба тэмдгийн нэртэй адил, нөгөө талаар, үйл үгийн адил өмнөх жинхэнэ нэрийг захирна. Энэ мэтээр монгол хэлний үгсийн нэг нь нөгөөдөө захирагдах, нэг нь нөгөөгөө захирах ёс нь хэлэхүүний талын үзэгдэл болох ба Ш.Лувсанвандан гуай захирах захирагдах ёсноо түшиглэж монгол хэлний үгсийг ангилсан бөгөөд тэрээр “Энд бид монгол хэлний үгсийг ангилахдаа цэвэр хэлзүйн нь шинж байрлал (дистрибуци) буюу хэлний аль нэг нэгжийн тохиолдож болох, үл болох

³¹ Энэ нэрийг бэлгэ тэмдгийн нэр (Ш. Ишдорж-1930), хүртээх ёс (Б.Ринчен - 1967, Энэ нь захирах ёсыг хэлжээ), тэмдэг үг (Ш.Лувсанвандан-1939). Тэмдгийн нэр (Ш. Лувсанвандан-1951), хүртээл нэр (Ш. Лувсанвандан- 1967), чанарын нэрс, харьцангуй нэрс (А.Бобровников-1949), чанарын нэр, (Н.Н. Поппе- 1937, 1940), хүртээл нэр (Н. Поппе-1951, Г.Д.Санжеев-1941), хүртээл нэрс, чанарын нэрс (Г.Д. Санжеев- 1952, 1951), хүртээл нэр- (Х.Б.Тодасва-1951), хүртээл нэр, чанарын хүртээл нэр, харьцангуй хүртээл нэр (А.А. Дарбеева-1962), хүртээл нэр (Н.Н.Поппе- 1960), тооны хүртээл нэр, тооны бус хүртээл нэр, (John Charles Street-1963) хүртээл нэр (Төмөр хайрцаг, төмрийн хайрцаг), чанарын харилцааны нэр (Заахаас бусад тийн ялгалаар өмнөх үгээ захирна), Ш.Лувсанвандан - 1967 (1968), тэмдэг нэр, (Л.Балдан-1987), хавсрал нэр (Чой Лувсанжав-1964), нэрийн тодотгол, тэмдэг нэр (Д.Төмөртоогоо -2004) гэх мэтээр нэрлэсээр иржээ.

орчин дээр нь үндэслэж, ангилахыг чармайсан билээ. Өөрөөр хэлбэл, үгсийг нөхцөлтэйгөө хэрхэн харьцах, нөхцөл нь үгстэйгээ хэрхэн харьцах дээр нь үндэслэж ангилах гэсэн хэрэг болно³² гэж тайлбарлажээ.

Харьяалахаас бусад тийн ялгал нь жинхэнэ нэрийг үйл үгтэй, харьяалахын тийн ялгал нь жинхэнэ нэрийг жинхэнэ нэртэй тус тус холбож, энгийн өгүүлбэрийг бүтээдэг бол үйлийн тийн ялгал нь үйл үгийг үйл үгтэй холбож, нийлмэл өгүүлбэрийг бүтээнэ. Гэтэл үл хувилах үг нь тодотгох тэг үндсээр жинхэнэ нэр, үйл үгнээ захирагдах бол цагт нэр нь жинхэнэ нэрнээ мөн тодотгох утга бүхий тэг үндсээр захирагдана. Үүнд: ³³



1. Зөвхөн үйл үгийн өмнө хамжин орно
2. Жинхэнэ нэрийг захирахаас гадна, жинхэнэ нэр, үйл үгийн өмнө хамжин орно
3. Харьяалах, гарахын тийн ялгалаар жинхэнэ нэрийг захирна.

N_{adv} буюу орон цагийн нэр нь 1. үйл ба хэрэг явдлын цаг орныг заах, 2. Нэрийн т.я-гаар хагас хувилах ба тэр дундаа нэрлэхийн тийн ялгалаар огт хувилдаггүй, 3. орон цагийн үгийн язгуур үндэснээ – “du, ki” дагавар залгаж үл хувилах тэмдэг нэр бүтээх, (qöyi-du umaga-du, ina-du, činadu: qöyina-ki, ende-ki, degereki, dēgedüki)

4. Орон цагийн нэрээр цаад юмыг солин нэрлэх (degere doura -ügei (бүх хүмүүс), kejiye ijaγa- ügei (мөдхөн), адилтгах (inagsi qara- тал өгөх), činaysi qara - (царай өгөхгүй, үхэх), qola kebtene (мөд бүтэхгүй), орны утгатай тэмдгийн нэрнээ орон цагийн нэр бүтээх даг-вар залгах зэрэг онцлогтой юм. (qola-γүг ire-, qola-āsa tani-, öyira-dayān boruγa-tāi, öyira qabi-dayān siγuγa-ügēi; утга салаалах: uruysi-ügēi (бүтэмжгүй), uruysi-tāi (бүтэмжтэй) qöyisilγa ügēi (хожмыг боддоггүй, хүний тусыг боддоггүй), qöyirγu (залхуу), qöyilγa (үхэгсэд дагалдуулах эд мал).

N_{adj} буюу тэмдгийн нэр нь тогтворгүй хувилах ба тогтвортой хувилах шинжтэй юм. (Дээрх хүснэгтийг үзнэ үү)

N_{numi} буюу тооны нэр нь нэрийн тийн ялгалаар огт хувилдаггүй юм. Тодотгох утгатай тэг үндсээр нэр үйл үгнээ хамжин захирагдана. Харин Ш.Лувсанвандан гуай "Гэтэл тооны харьцааны нэрс нь нэрлэх, харьяалахын тийн ялгалын хэлбэрт орсноос бусад тийн ялгалын хэлбэрт нэрсийг захирч чадахгүй. Жишээ нь гурван

³² Ш.Лувсанвандан, Монгол хэлний үгсийг аймаглах тухай асуудалд. ХЗ хүрээлэн, Хэл зохиол, V боть, УБ, 1964, 40-41-р т.

³³ М.Базаррагчаа Монгол хэлний өгүүлбэр судлал, УБ, 2005, 224-рт

N_{sub} - жинхэнэ нэр, V - үйл үг, $Э.Ө$ - энгийн өгүүлбэр, $Н.Ө$ - нийлмэл өгүүлбэр, N_{adj} - тэмдгийн нэр, N_{adv} - орон цагийн нэр, N_{num} - тооны нэр, N_{fig} - дүрс дуурайх үг, N_{onom} - авиа дуурайх үг, V_1 - тусах ба эс тусах үйл үг, V_2 - цагт нэр, (N_{parti})

гурав -ес, Чиний гурав, Ахын тав гэсэн нь зөвхөн хэлэхүүний үүднээс хураасан заримдаг холбоо үг өгүүлбэр юм. Эдгээр тооны нэрийн цаанах жинхэнэ нэр нь хураагдсан ажээ. Гурван үхрийн гурав дахин өсгөвөл есөн үхэр болно. Ахын таван морь, Чиний гурван тэмээ гэх мэтээр дэлгэрэх нь үүнд тооны нэр нь тэмдгийн нэрсийн адил тийн ялгалаар хувилахгүй юм.

N_{fig} , N_{onom} буюу дүрс ба авиа дуурайх үгс нь зөвхөн үйл үгийн өмнө, ялангуяа "ki, ge-, keme-" үйл үгийн өмнө хамжин тодотгох үүргээр орж захирагдана. Жишээ нь "Тас хийм хүйтэн бүхий биеийг жихүүцүүлэн, яс хийм байдал хамаг сэтгэлийг зэвүүцүүлнэ. (Д.Н) - Өвчүүний яс чам чам өвдөхөөс амьсгаа авахад гэмгүй боллоо гэж гэрийн эзний царай маш баяртай (Б.Р), Өвгөн Шанзав, амбан сайдын дээрх үгийг сонсоод, уруулаа өмөр өмөр хөдөлгөөд, өвөгжөөр хүний ажиг хэнэггүй дуугаар өгүүллүүн: ... (Б.Р)

$V \leftarrow V_1$ нь монгол хэлний үйлийн тийн ялгал бөгөөд нийлмэл өгүүлбэр бүтээх цөм нэгж буюу цөм нөхцөл мөн. Жишээ нь 1. Палам хаалга аяархан тата-ж, ор-оод, бага хүү, том охин хоёроосоо нүд буруул-н малгай пальтогоо өлгө-ж удаан зогсов. (С.Э) гэсэн хэлхэц өгүүлбэрийн төгс бус өгүүлэхүүн нь үйлийн тийн ялгалын нөхцөлөөр хэлбэржжээ.

2. Борлосон нүүр нь хөрстэй агаад өнгөтэйгөөр үзэгдэ-ж

Сортгор нүд нь сэргэлэн бөгөөд цогтойгоор гэрэлтмүй. (Д.Н)

3. Сумьяа "За, сайхан унтаарай хэмээ-г-ээд чинагш явав. (Д.Н)

Хуучин танил гэж худал хэлэн, Хоршооны түшмэл гэж хоймор сууна. (Д.Н)

4. Цай авчраад өгөхөд нь "За за, зүгээр зүгээр" гэнэ

Цаашаа аваад явахад нь "За яахав, нэг хийгээд аль" гэнэ. (Д.Н)

V_2 - N_{sub} цагт нэр ($V_{participle}$, V_{parti}) нь дээр өгүүлснээр, ямагт жинхэнэ нэрийн өмнө тодотгох утга бүхий тэг үндсээр хамжин орж, тодотгох гишүүн өгүүлбэрийн төгс бус өгүүлэхүүн болно. Жишээ нь: 1. Хичнээн сайхан салж болмооргүй ертөнц боловч Гэээгтийн дуулдаг өвгөн шувуу буцах цаг болжээ. (С.Э)

Нэг голын, нэг үеийн өвгөцүүл урт амьдрал туулж, насан хэвийх(ийн) жам ёсоор уван цуван цөөрсөөр боловч залуу зандан цагийнхтайгаа адил бие биеэ нэрээр нь биш, хочоор нь дуудаж, наануу цаануутай явах учир нэг нь ингэж тасраад талийчихна гэдэг амьдрал өм цөм үсэрнэ гэсэн үг. (С.Э). Эрүү өвдгөө тулсан эмгэн өвгөн хоёрыг орхиод явах гэж үү? (Ц.Д) Нүдий нь аниулж, ясы нь барих ураг элгэнгүй, өнчин өрөөсөн, өвчтэй хүнийг амьдаар нь нутаг дээрээ гэж нүүх феодалын хуучин заншил мөн ч хатуу яа. (Б.Ө)

Тухайн авиалбарт бусдаас ялгарах ба бусадтай нийлэх хэд хэдэн шинж байдаг шиг тухайн үгэнд мөн тийм байдаг. Үгийн утгыг бүрэлдүүлэгч шинжийг утганцар буюу семгэдэг. Үүнийг Луй, Ельмслев Фигура Содержания (агуулбарын ялгаварлах шинж) буюу агуулбар (плерема)-ын бүрдвэр гэж нэрлэжээ.³⁴ Жишээ нь, "гэр гэвэл, хүний сууц, эсгий мод" гэсэн гурван утганцрыг агуулж байна. Мөн мод гэдгийн цаана хана, унь, тооно, "эсгий" гэдгийн цаана "туурга, дээвэр, цаваг, өрх" гэсэн зүйлийн утгыг хадгалж байна. "Бүсгүй" гэвэл "эмэгтэй, хүнтэй

³⁴ Энэ утганцрыг "сема, семантический дифференциальный признак, семантический множитель, семантический примитив, смысловой атом, фигура содержания, конечный компонент смысла, минимальный элемент смысла, минимальные единицы значения" гэх мэтээр нэрлэдэг байна.

суугаагүй, залуу" гэсэн утганцартай бол "хүүхэн" гэвэл "эмэгтэй, биед гүйцсэн боловч эрд гараагүй, залуу" гэсэн утганцрыг агуулжээ. "Эрдэм" гэвэл "мэрэгжил, мэдлэг, чадвар" гэсэн утганцруудтай бол "ном" гэвэл "туурвисан бичиг зохиол, эрдэм мэдлэг, ном ёс" гэсэн утганцруудтай юм. "Эвхэх" гэвэл "юмыг авсаархан болгох, хуйлах нугалах, багцлах цэгцлэх" гэсэн утганцартай бол "шивэх" гэвэл "хатгах, цоолох, нягт оёх" гэсэн утганцартай болно. Энэ утганцрууд нь салаа утга үүсэх эх болохын зэрэгцээ өөр үгтэй утгаараа зохицох боломжийг нээдэг.

Луй Ельмслев үгийн утга-хэлзүйн харьцааг 1. "Тогтворгүй ← тогтвортой" буюу захирагдах захирах угсарсан харьцаа нь сонгон ялгах утгатай (аргаар /ажилд/ бодлогоос хялбар гэхэд чанар заасан "хялбар" гэсэн тэмдгийн нэр нь гурван тийн ялгалт нэрийг сонгон, зохих утгыг ялгана); 2. "тогтвортой → ← тогтвортой" буюу харилцан угсарсан харьцаа нь бат нэгдэж, иж утгатай ("санаа-□ муут-□ яван хатна" гэхэд "муут" гэсэн тэмдгийн нэр нь нэрлэхийн тийн ялгалаар "санаа" гэсэн жинхэнэ нэрийг захирсан бол нэрлэхийн тийн ялгал нь "муут" гэсэн тэмдгийн нэр өгүүлэхүүнийг тогтоож, уг юмын шинж чанарыг тодорхойлж байна). 3. "тогтворгүй: тогтворгүй" буюу харилцан зэрэгцсэн харьцаа нь хоёр үг нэг нэгнээ үл захиран чөлөөтэй хоршиж, ойролцоо ба эсрэг, чөлөөт ба зүйлийн элдэв утгатай байдаг (удаан түргэн, өндөр намгүй, үрчгэр мурчгэр, элдэв дээд) гэж ангилжээ.³⁵

Ингэж, угсрах, харилцан угсрах, зэрэгцэх" гэсэн харьцаанаас, тэмдгийн нэр нь үйлдэх, өгөх орших, гарахын тийн ялгалаар өмнөх жинхэнэ нэрийг захирах (угсрах) нь хэлэгдэхүүний талд, ямар утгатай тэмдгийн нэр нь аль тийн ялгалаар өмнөх жинхэнэ нэрээ захирч буй нь мэдэгдэхүүний талд тус тус холбогдоно. Монгол хэлний тэмдгийн нэр нь 1. шинж чанар (сайн, муу, цэвэр, бохир, мэргэн, тэнэг, хатуу, зөөлөн), 2. тоо хэмжээ (арвин хомс, том бага, бүхэл хагас, өргөн нарийн, хөгшин залуу), 3. хэлбэр дүрс дүрс (Хурц мохоо, муруй тэгш, гонзгой навсгар, майжиг жайжиг, налуу эгц), 4. Өнгө зүс (хар цагаан, буурал саарал, алаг эрээн, хээр халтар, улаан цагаан) 5. орон зай (Хол ойр, дотор гадар, чанад янад, баруун зүүн), 6. цаг хугацаа (Удаан түргэн, алгуур аажим, шахуу шахам) гэж ангилж болно³⁶. Сонгон ялгаж, шинэ өвөрмөц уран дүрслэл бүхий тэмдэг нэрийн холбоо үг бүтээх нь хэлэхүүний талд хамаарна. Үүнд: 1. Шинж чанар (хүйтэн харц, хатуу шаардлага, халуун нүүр, шингэн мөр, хатан зориг) 2. тоо хэмжээ (бутархай мөнгө, нарийндаа хатах, охор бодол), 3. Хэлбэр дүрс (бөөрөнхий үзэл, хэлтгий заяа, алаг махны тасархай, бүдүүн хүзүү гаргах, бие давхар), 4. Өнгө зүс (улаан суга, нойлын ногоон тэг, хар толгой, шар өвчин, хар шөл, хар хүн, хонгор сэтгэл) 5. Орон зай (хойд эцэг, баруун гар, аглаг төрөл, авд аглаг хүн), 6. Цаг хугацаа (удаан хөлтэй, түргэн түүхий, хурдан буу, түргэндээ орох).

Мэдэгдэхүүний талд, сэтгэл догдлол хийгээд үнэлэх утгын махбодь оролцдог.³⁷ Жишээ нь:

³⁵ Луй Ельмслев. Прологомы к теории языка, "Новое в лингвистике. Вып. I. Издательство Иностранной литературы", М., 1960, стр. 299

³⁶ М.Базаррагчаа "Монгол хэлний өгүүлбэр судлал" УБ, 2005, 165-166 р т.

³⁷ Б.И.Косовский Общее языкознание, Учение о слове и словарном составе языка, Издательство

Хайртай амраг хурц аа!

Хагацах өдөр бас байжээ! (Д.Н) гэхэд "хурц" гэсэн чанар заасан тэмдгийн нэр өгүүлэгчийн сэтгэлийн гүн догдлолыг илэрхийлж, "аа" гэсэн батлах утгат баймжит бүтээврийг дагалдуулжээ.

"Зуны цагийн найртай сайхан өглөө

Энэ дэлхийд юутай сайхан тааламжтай вэ? (Д.Н) гэхэд асуух өгүүлбэрийг сэтгэл хөдөлгөсөн өгүүлбэр болгохын зэрэгцээ, тэмдэг нэрийг хоршин, эсрэг сэтгэл хөдлөлийг илтгэжээ. Залуу насаа хайрлаж явахыг "Залуу насанд үхэхийг хэн хүснэ

Бүү өгүүл, хэн ч үл хүснэ

Насан хутгийг гуйхыг хүснэ үү

Бүү өгүүл, хэнээс ч үл гуйна. (Д.Н) гэж өвчин үхлийг эрс эсэргүүцсэн сэтгэлийн догдлолыг илэрхийлсэн байна. Үүнд "залуу" гэсэн чанарын тэмдгийн нэрийг "насан хутаг (үхэл зовлон, өтлөх)- тай эсрэгцүүлэн тавьжээ.

Тэмдгийн нэр юмсын эерэг сөрөг шинжийг илтгэх тул уг юмын үнэт зүйлсийг агуулж байдаг. Дараах жишээнд орсон тэмдэг нэр нь манай залгамж болсон залуу үеийнхний хэчнээн үнэ цэнэтэй болохыг харуулжээ. Үүнд:

- Хойчийг залгамжлагч пионер нар эртлэн босоод

Хүйтэн булгийн усаар нүүрээ угаана

Дөрөв дөрвөөр эгнэн жагсаж явах бөгөөд

Нүцгэн шилбүүд нь чийрэг агаад шулуун

- Эгнээ бүрийн дундаас дуурсаж бүхий дуу нь

Тунгалаг болоод өндөр, яруу болоод сайхан

Сэтгэл зориг нь нэгэнт хөгжсөнд

Уул боловч асар өндөр бус

Тал боловч төдий л хол бус

Туйлын гүн далайгаас үл эмээнэ (Д.Н)

Өнгөн бүтцийн үүднээс тэмдэг нэр нь байхгүй боловч гүн бүтцэдээ ил болон гарч ирэх нь бий. Тухайлбал:

- Алсын салхи жихүүн амьсгалаар тас няс хийхүй дор

Алтан дэлхийн уул тал мөнгөн хуягийг өмсөнө (Д.Н) гэхэд "алтан, мөнгөн" гэсэн адилтгасан жинхэнэ нэр нь, "цаанаа алт мэт шар дэлхий, мөнгө мэт цагаан хуяг" гэсэн гүн бүтэц тодорч: өнгө заасан тэмдэг нэрийг хурааж, адилтгахуунд тохсон байна. Үүнд монголчууд юуг юутай ямар шинжээр адилтгах нь уламжлалт сэтгэхүйн онцлогийг агуулдаг.

Б.Н.Головин үгийг мэдэгдэхүүний талаас нэрлэх ба заах, шууд ба шууд бус утгат, бодит ба хийсвэр утгат, мэдэхүүний талаас ерийн ба нэр томьёо, дүрслэх ба дүрслэх бус, сэтгэл хөдлөлийн ба сэтгэл хөдлөлийн бус утгат, хэлэгдэхүүний

талаас ойролцоо ба эсрэг утгат, үүсмэл ба үүсмэл бус, хэлц ба хэлц бус утгат³⁸ гэж ангилсан байдаг. А.А.Груцкий сэтгэл- үнэлэмжийн утга буй эсэхээр нь "зам, амьдрал, гол, бодох, хийх, би, чи, ус" зэргийг сэтгэл-үнэлэмжгүй үгс, "бүтээн цогцлуулах, айсуу, төлөвлөх, туурвил, тогтнох", (эрхэмлэн хүндэтгэх утга) "увайгүй, бялдууч, гөлрөө, гөлрөх" (үл ойшоох утгат), хоншоор нь дутах, усан тэнэг, яхир ярдаг, уймар (доод найруулгын үгс) зэрэг сэтгэл үнэлэмжийн үгс³⁹ гэж ангилсан байдаг.

Хэлний нэгжүүд нь тухайн эх буюу нөхцөл байдлаас шалтгаалан, өгүүлэгч этгээдийн сэтгэл хөдлөх, уг юмсыг үнэлэх, уран дүрслэх, уламжлалт заншил, соёлын махбодыг хадгалах, харилцагч этгээдээ хүндэтгэх зэрэг нэмэлт утга, утганцрыг агуулж байдаг. В.И.Шаховский "Өнөөгийн сэтгэл хөдлөлийн ухаанд сэтгэл хөдлөл нь ухамсар сэтгэхүйн бүтцэд багтах учир хүний танин мэдэх үйл явц, сэтгэх соёл, арга маягтай холбогддог. Сэтгэл хөдлөх бүр нь хүний сэтгэл хөдлөлийн утга санааг агуулсан өвөрмөц дохио тэмдгийг бүтээдэг. Сэтгэл хөдлөл нь мэдлэг, оюунтай нягт холбогдохын хирээр оюун санаа нь өөрчлөгдөж, хувирч байдаг хэмээн үзжээ⁴⁰. Үүнээс бид сэтгэл хөдлөл нь танин мэдэхүйн шат бүрд нөлөөлж оролцдог хэмээн ойлгож болно.

	Улаан лооль Улаан арьстан	Улаан хүрэн Цагаан цэнхэр	
Гүн бүтэц	Бодит утга	Харьцааны утга	Хам бүтэц \хэлэгдэхүүн\
Өнгөн бүтэц	Найруулгын утга	Салаа утга	Цуваа бүтэц \хэлэхүүн\
	 Улаан → худалч Улаан → гараараа	 Улаан → салхи Улаан → арми	
	Улаавтар - улаахан Улаантан, цагаантан	Улаан нүүрэн дээр Улаан хоолой	

гэхэд "гал цус мэт өнгө" гэсэн утга нь бодит шууд утга болох ба улаан хүрэн: цагаан цэнхэр гэвэл "улаан, цагаан" гэсэн өнгө нь өөр хоорондоо эсрэгцэх боловч, "улаандаа гарах, цагаандаа гарах" гэснээс "улаан, цагаан" гэсэн хоёр үг нь ойролцоо утгатай болно. "Улаан" гэдэг үг нь үндсэн утгаасаа гадна 1. хувьсгалын утга чанар, (улаан гэр), 2. муу юманд мэргэн (улаан худалч, улаан луйварчин), 3. шууд ил (улаан зам дээр, улаан суга, улаан дайрах), 4. нялх балчир (улаан нялзрай, улаан цурав), 5. шунахай ховдог (улаан нүдтэй, нүд улаан, мөнгө цагаан), 6. хэтрүүлэх буюу эрчимжүүлэх (улаан галзуу, улаан

³⁸ Б.Н.Головин Введение в языкознание, Издательство, "Высшая школа", М. 1944, стр 73-79

³⁹ А.А.Гируцкий Введение в языкознание, Издательство, "ТетраСистема, Минск, 2003, стр 123

⁴⁰ В.И.Шаховский Эмоции, Долингвистика, лингвистика, лингвокультурология, Издательство "Книжный дом, ЛИБРОКОМ" М. 2009, стр 13, 22, 44

нүцгэн), гэсэн утгатай юм⁴¹.

Ертөнцийн гурван улаан (Жавартай тэнгэрийн хаяа нэг улаан, жаргалтай хатны хацар нэг улаан, жалганд ургасан сухай нэг улаан), улаан өндөгний баяр (Христийн шашинтны хаврын баяр) гэхэд орсон “улаан” хэмээх үг нь тухайн улс үндэстний өвөрмөц онцлогийг хадгалсан үг хэллэг болсон ба “улаан арми, улаан цэрэг, улаан булан, улаан толгой, улаан данс, улаан ном, улаан гэр” гэвэл бэлгэдэл соёлын үнэлэмж бүхий утгатай юм. "Улаан мөнгө" (зэс гуулиар үйлдсэн зоос), "улаан галзуу" (догшин ширүүн), "улаан мөнгөний үнэгүй" (үнэ цэнэгүй хямдхан), "улаан цоохор болгох" (муу найруулгын алдааг зассан нь), "улааныг үзэж урвах, шарыг үзэж шарвах" (бусдад зусардан маяглах), улаан салхи, улаан нэлий, улаан хоормог, улаан ёлхдос (цусан суулга), улаан шороо, улаан шуурга, улаан нүцгэн (ядуу, тачир газар), улаан дайрах (нүүр нүдгүй дайрах), улаан дээрэмчин, улаан яргачин, улаан луйварчин, улаан худалч, улаан тонуулчин, улаан галзуу, долоон согтуу, улаан нүдтэй (шунаг), Мөнгө цагаан, нүд улаан (хэт шунамхай) зэрэг үг өгүүлбэр нь сөрөг үнэлэмж бүхий нэмэлт утгатай бол "улаан хөлтийг урдуураа гаргахгүй, улаан хэлтийг урдаа оруулахгүй (чадмаг, гаргуун, хурдан түргэн) гэвэл эерэг утгатай байх ажээ. Тэгвэл “Улаан” гэдэг нь “ил, тодорхой, шууд” гэсэн утгатай “улаан нүүрээрээ учрах, улаан зам дээр учрах” улаан нүүрэн дээр нь хэлэх, улаан сугаар нь (яг сугаар нь) улаан гараараа, улаан тулгарах” гэсэн хэлц байх ба "Улаан нялзрай, улаан цурав, улаан цах гэх хэлц нь “дөнгөж төрсөн нялх” гэсэн утга илтгэнэ. Эдгээрт орсон "улаан" гэх тэмдгийн нэр нь давуулан эрчимжүүлсэн байж утгыг агуулж байна. Мөн "улаан голоо тасартал (амьсгал хураатлаа, үхэн үхтлээ) (солин нэрлэх), улаан хоолой (амь амьдрал) (солин нэрлэх), улаан мөнгө (үнэ цэнэгүй) (төлөөлүүлэн нэрлэх), улаан зээрд (баахан согтох), (төлөөлүүлэн нэрлэх), улаан тулам (говийн олон наст ургамал) (адилтган нэрлэх), улаан гараараа (нүцгэн гараараа) (төлөөлүүлэн нэрлэх), улаан яргачин (алж талах нь хэтрэгч) (төлөөлүүлсэн нэрлэх)” гэх мэт хэлц үгс нь сэтгэлгээний онцлогийг, тухайлбал монголчууд "улаан" гэсэн өнгө заасан үгээр ширүүн, хэрцгий хар хүч, шунахай ховдог, амин чухал, нялх балчир” гэсэн өвөрмөц соёлын утгыг илэрхийлдэг байна. "Улаан бурхан" гэхэд эерүүлэн цээрлэсэн нэрлэлт болно. Ийнхүү "улаан" гэсэн үг нь "эерэг сөрөг үнэлэмж, уран дүрслэл зэрэг нэмэлт утгыг илтгэдэг байна. Энэ үг нь гал цус буюу тэдгээрийн өнгөтэй ихээхэн холбоотой ажээ.

Орос хэлнээ “красный” гэсэн тэмдэг нэр нь 1. улаан өнгө, 2. хувьсгалын үйл хэрэгт хамаарах шинж, 3. сайхан, (красивый, прекрасный), 4. баяр баясгалан, аз жаргалтай, 5. тод хурц, гэрэл гэгээтэй, 6. ёслол хүндэтгэлийн, 7. ургамлын шинж, (красный лес), гэхээс гадна, красный зверь (үнэт арьстай том амьтан), красный товар (толгой бараа), красный уголок (улаан булан), улица красных уголок (улаан дэнлүүний гудамж, янхны газар), красное словцо (хошин үг, алиа яриа), красная строка (догол мөр, улаан мөр), красная линия (улаан шугам, босго оноо), красная цена (дээд үнэ, ханасан үнэ), пустить красного петуха (галдах, гал тавих) проходить красной нитью (гол утга нь) гэсэн утга илтгэдэг байна⁴². Үүнээс улаан,

⁴¹ Монгол хэлний тайлбар толь Эмхэтгэн боловсруулсан Н.Даш, А.Янжиндолгор "Мон судар" хэвлэлийн газар, УБ, 2014, 1336-1338-рт

⁴² Словарь русского языка, Т. II к-о, Издательство "Русский язык", М, 1983 стр 122, Большой

красный гэсэн үг юугаараа адил, юугаараа ондоо байгааг харьцуулан үзнэ үү.

В.И. Шаховский, сэтгэл хөдлөхүй”-г "эмотиология". Сэтгэл хөдлөлийн бичил махбодийг "эмосемы гэж нэрлэсэн ба сэтгэл хөдлөлийн хэмжүүрт, сэтгэлд таатай таагүй байх, сэтгэл эрчтэй, эрчгүй, тайван хөхүүн байх шинжийг дурджээ⁴³. Тэрээр, сэтгэл хөдлөлийг нэрлэх, дүрслэх, илрүүлэх үг, өгүүлбэр байдаг ба эдгээр нь хоолой чичрэх, царай улайх, цайх, догдлох зэрэг биеийн хэлтэй давхцаж байдаг гэжээ⁴⁴. Жишээ нь: -Юун улс вэ? Бушуу гараад ир гэж Бадарч өндөр дуугаар зандран хашхирав. (Дээрэлхэн гайхуулсан сэтгэл хөдлөлийг "өндөр дуугаар зандран хашхирав" гэсэн өгүүлбэрээр нэрлэжээ), - Танай үүгээр ганц нэг сэжигтэй хүн яваагүй биз? гэж Бадарч бүдүүн тэнзэн ташуураа мориныхоо шилэн дээгүүр хөндлөн барьж сүр бадруулан асуув. (Ч.Л) (Үүнд өндөр, бүдүүн, хөндлөн, гэсэн тэмдгийн нэр нь сэтгэл хөдлөлийн байдлыг нэрлэх чухал үүрэгтэй бөгөөд "сүр бадруулах гэдэг нь сэтгэл хөдлөлийг дүрсэлсэн үгс болно.

- Явсан байх аа! Урьд шөнө тэрэгний ганц морийг минь мулталчихлаа гэж Эрдэнэ намуухан дуугаар өчив. (сэтгэл хөдлөлийг ерийнөөр нэрлэн өгүүлжээ)

- Юу гэнэ ээ. Морио харж чадахгүй, оргодолд хөл залгаж өгнө гэнэ ээ гэж хэлэхэд Бадарчийн нүүрний бүх арьс нь хянган хамар дээрээ бөөгнөрөв. (Ч.Л) (сэтгэл хөдлөлийг дүрслэн нэрлэжээ.)

- Хэдийд ирж авсныг мэдсэн бол би хаанаас алдах билээ. Дор нь барьж аваад та бүхэнд тушаачихгүй юу гэж хариулахад Бадарч бүдүүн дуугаар пар пар инээн Дамдин руугаа харж" Барина гэнэ шүү. Энэ зэргийн Дулдрай хүү барих юм гэнэ. Мөн бордог эр ээ гэснээ, гэнэт инээхээ больж, хөмсгөө зангидан "Гуйланчин минь чам шиг юманд баригдах эр биш. Будааныхаа савтай хоцорсноо их аз гэж мэд. Засагт ханы цахиур Төмөрт морио алдсанаа мэдэж байна уу.

"Барина гэнэ шүү" гээд дахин инээв. (Ч.Л) гэхэд "гэ-" үйл үгийн ар дахь өгүүлбэр нь сэтгэлийн хөдлөлийг нэрлэсэн ба дүрсэлсэн өгүүлбэрээр илтгэж байна. Харин сэтгэл хөдлөлийг илтгэсэн үг өгүүлбэр нь Бадарчийн хэлсэн үгс болно. Дээрх жишээнд "Өндөр дуу, бүдүүн дуу- намуухан дуу" (эсрэгцэх утга), ганц нэг хүн- ганц морь (давтсан үг), дулдрай хүү, бордог эр, чам шиг муу юм гэх мэт ил далд тэмдгийн нэр нь сэтгэл хөдлөлийг нэрлэх, дүрслэх, илтгэхэд чухал үүрэгтэй аж. Ийнхүү бие хэл сэтгэл хамтарч бүтсэн утга санааг хам хэл шинжлэл (Паралингвистика) гэнэ.

Ам түргэн, задгай гэвэл захирч буй түргэн, задгай гэсэн тэмдэг нэр нь "ам" хэмээх үгийг тийн ялгалаар захирвал идэвхтэй зохицол, харин "ам" нь дараах тэмдгийн нэрнээ захирагдахыг идэвхгүй зохицол гэх ба энэхүү захирах ёсыг зайлшгүй буюу тогтвортой, санамсаргүй буюу тогтворгүй гэж ялгадаг⁴⁵. Тухайлбал, монгол хэлнээ жинхэнэ жинхэнэ нэр нь өмнөх жинхэнэ нэрээ заавал

академический русско-монгольский словарь. Т-2, Е-О. "Наука-восточная литература" м., 2014, стр. 472.

⁴³ В.И.Шаховский, Дурдсан зохиол, стр 9

⁴⁴ В.И.Шаховский Дурдсан зохиол, стр 34

⁴⁵ В. Г. Гак. Валентность "Лингвистический энциклопедический словарь, "Издательство Советская энциклопедия" М., 1990, стр 80

харьяалахын тийн ялгалаар захирна. Орон цагийн нэр нь өмнөх нэрээ гарах ба харьяалахын тийн ялгалаар захирч, мөн өөрөө энэ хоёр тийн ялгалаар дараах нэр ба үйл үгнээ захирагдана. Үүнийг тогтвортой захирах захирагдах ёс гэнэ.

Монгол хэлнээ тэмдгийн нэр нь өмнөх жинхэнэ нэрээ нэрлэхийн тийн ялгалаар захирах нь хэлц өгүүлбэрт олонтоо тохиолдож байна. Жишээ нь ам-□ азгай, ам-□ халамцуу, ам-□ хатуу, ам-□ зөөлөн, ам-□ хуурай байхгүй, зүрх-□ муутай, магнай-□ тэнүүн, нохой-□ явган, гахай-□ нүцгэн, нэхэл-□ хатуутай, өр-□ нимгэн, сав-□ хоосон буцаахгүй, ухаан-□ богино, хөл-□ нэгтэй, хөл-□ хүнд, цөс-□ ихтэй, чих-□ урт, чих-□ хатуу, элэг-□ буруу, элэг-□ бүтэн, гэж байхад тэмдгийн нэр нь үйлдэх, өгөх орших, гарахын тийн ялгалаар захирах нь ховор юм. Жишээ нь Хорхойд хоргүй, Үгэнд дуртай, нүдэнд дулаан, нүдэнд хүйтэн, нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой, голдоо нүхтэй мах, адилдаа адил, годилдоо годил гэхчлэн өгөх оршихын тийн ялгалаар захирсан нь цөөн байна. Мөн тэмдгийн нэр нь өмнөх жинхэнэ нэрээ харьяалахын тийн ялгалаар нь захирах нь багагүй тохиолдож байна. Үүнд: "Алаг бөөрийн холбоотой, Алганы хонхорхой хазах, Яс махны тасархай, шилний хонхор харуулах, хуучин бууны хугархай, ходоодныхоо мухарт хийх, хөгшин хонины насгүй, мордохын хазгай, газрын мухар, амны хишигтэй" гэх зэргийг дурдаж болох бөгөөд жишихийн тийн ялгалаар өмнөх жинхэнэ нэрийг захирсан тэмдгийн нэр нь хэлцийн дотор олон тохиолддог ба ихэвчлэн захирсан тэмдгийн нэр нь гээгддэг. Архины лүү" гэхэд архины лүү шиг том саванд архи их ордог гэсэн дэлгэрэнгүй өгүүлбэрээс хураагджээ. "Арцсан толь шиг (тунгалаг), Алгын чинээ (бага), буруу ишилсэн сүх шиг (зөрүүд), бээлийн чинээ (өчүүхэн), бурхан шиг (номхон, төлөв) амьтан, газар тэнгэр хоёр шиг (эрс ялгаатай), газрын бэтэг шиг (арвигар), газрын гаваар орсон юм шиг (алга болох), Дэнгийн эрвээхий шиг, (хөнгөн) гал ус хоёр шиг (эрс тэс ялгаатай), зургийн хуар шиг (үзэсгэлэнтэй). Зурсан юм шиг (сайхан), Нар сар хоёр шиг (өөр), нойтон хамуу шиг (наалданхай нялуун), нүх шиг харанхуй, туулай шиг зүрхтэй, ус цас шиг (элбэг). Утайн хуушаан шиг (наалдамхай), үнхэлцэг (мэт өчүүхэн) баатар, хаврын тэнгэр шиг (олон ааштай), Халуун цаг дээр суусан юм шиг (тогтворгүй), хайлсан тугалга шиг (хөнгөн шингэн ааштай). Харвасан сум мэт (түргэн), хатсан борц шиг (туранхай, хатуу). Хонь чоно хоёр шиг (өстэй). Хуй салхи шиг хурдан, хувингаар цутгах шиг (ширүүн), хуйхууд хөөгдсөн юм шиг (ум хумгүй), хуруун чинээ (жаахан), шуудайнд хийсэн үхрийн эвэр шиг (эв түнжингүй), эрхийн чинээ (өчүүхэн) цэцэг цэврүү шиг (хөөрхөн), чигчийн чинээ (өчүүхэн) шаасангадас, шахсан бяслаг шиг (бат нягт) шар тос шиг үгтэй (урамтай) гэх мэтээр адилтгагдхуун ба ямар шинжээр адилтгасан шинж тэмдгийг заасан тэмдгийн нэр, заримдаа "шиг мэт, чинээ" гэх мэт холбоосыг орхиж зөвхөн адилтгахуунаар илтгэсэн байна.

Ийнхүү монгол хэлний хэлц нэгжийн дотор жишихийн тийн ялгалаар хувилсан жинхэнэ нэрийг захирсан тэмдгийн нэр бүхий үг өгүүлбэр нэлээдгүй тохиолдож байгаа нь нэг юмын шинжийг нөгөө юмын шинжтэй адилтган сэтгэгдгээс үүдэлтэй бөгөөд хэлц нэгжийн дотор тогтворгүй захирах ёс давамгайл шинжтэй байгаа нь сонирхолтой юм. Тогтвортой захирах ёс нь тогтвортой хэлцэд олонтоо тохиолдмоор санагдавч тогтворгүй захирах нь тогтвортой хэлцэд олон

тохиолдож байгаа нь дээрх жишээнээс харагдаж байна.

Хэлний хөдлөнгө талаас нь авч үзвэл, тухайн нэгж нь мэдэхүүний хувьд : өгүүлэгчийн сэтгэл хөдлөл ба баймжийн шинж тод илэрдэг бол хэлэхүүний хувьд өгүүлэгчийн дүрслэх ур чадвар, үнэлэн үзэх хир хэмжээ ямагт хадгалагдсаар байдаг. Жишээ нь, “шар тос шиг үг” гэвэл эрхэмсэг үнэлсэн, "үнэн сайхан, чанартай, амттай" гэх мэт үг нь гээгдсэн боловч адилтгахуун (шар тос)-аар зохих үнэлэмжийг илтгэжээ. Хэрэв “шар тос” гэсний оронд "алт шиг үг" гэж болно. Ингэж "шар тос, алт" хэмээх хоёр нь огт өөр үгс боловч адилтгахуун болохын хувьд сонгож болох ойролцоо утгатай ажээ. Үүнийг дүрслэх ур чадвар гэж болох ба сонгон холбох чадвар нь үнэлэмжтэй холбогдоно. Энэхүү "шар тос шиг үг" гэсэн хэлцэд уг юманд сэтгэл таатай буйг илтгэх эерэг баймж, сэтгэлийн хөдлөл дагалдаж байх нь тодорхой юм. Үүнийг экспрессивность (дүрслэх яруу чанар) гэх ба В.Н.Гридин уг юманд хандах хандлага (шар тос шиг үнэ цэнэтэй), эерэг сэтгэлийн өнгө аяс хоёр адил болон ижилсдэг ⁴⁶ гэж үздэг. О. С. Ахмоновагийн ялгаснаар, тэмдгийн нэрнээ захирагдаж бүтсэн хэлц нэгжүүд нь чөлөөт бус яруу чанарыг агуулж байна. И.М. Кобзеба орос хэлний “восхищаться” (шагшин гайхах, дур булаах) гэсэн үг нь уг юманд сэтгэл татагдах байдлыг илтгэх тул тэр юм нь сайн сайхан байна гэсэн утга санааг агуулдаг⁴⁷ гэж үзжээ. Тэгвэл “уурлах, хилэгнэх, хайрлах энхрийлэх, үзэн ядах, нэг нүдээр ч үзэхгүй, ад шоо үзэх, өвчигнөх дөвчигнөх, муухай заваан, хэрүүл, үмхий санаа, хараах ерөөх, цухалдах – инээх баясах” зэрэг үгс нь сэтгэл хөдлөл бүхий эерэг сөрөг үнэлэмжийг агуулна. Үүнчлэн сайн-муу, сайхан- муухай, цэвэр- бохир, халуун- хүйтэн, намуун- дөлгөөн, догшин-хэрцгий, зөөлөн- хатуу, эелдэг- хэрцгий, хурц- мохоо, хуурай- нойтон, хуурамч-үнэнч, худал-үнэн, зөв-буруу, хар-цагаан, тэгш - хазгай гэх зэрэг эсрэг утга бүхий тэмдгийн нэр нь эерэг сөрөг үнэлэмжийг агуулдаг. Жишээ нь:

- Үнэн үг хэлсэн хүнд ноён дургүй, үхэр унасан хүнд нохой дургүй
- Бушуу туулай борвиндоо баастай гэж ийм хүнийг хэлдэг байж (Б.Р)
- Ёстой хорхойд хоргүй амьтан даа., хөдөө бөглүү буйд нутагт сууж, гайхалтай уран юм хийж суудаг хүн дээ (Б.Р)
- Энэ үг надад алтнаас үнэтэй, сувднаас сайхан санагдаж байв. (Б.Р)
- Муугаас муу, модноос хөө гэж энэ муу манд, бас өвчний төдий төвөг татав аа даа (Б.Р)
- Чимх мах, чимх ааруул хүртэл тоолж өгдөг эхдээ зовлонгоо тоочъё гэвэл хэдгэнэ шар зөгийн үүрийг хөндсөнөөс дор (Б.Р)
- Харчин хошуунд ийм жүйл үгүй, Чоно ойрхондоо ээлтэй гэгчээр энэ жүгт сүрхий ханилан ажих аваас,, нэгэн өчүүхэн хошуу хэмээн тоохгүй (Б.Р)
- Сайн айлчинд хүүхэд нохой хоёр дуртай гэдэг билээ. (Б.Р)
- Ер нь эвэртэн сүүлтэнд нүүр талтай байх нь дээр ... (Б.Р)

Н.Нансалмаа, expression (яруу чанар)-ыг,,...үгийн бодот утгатай адил тэгш,

⁴⁶ В.Н.Гридин Экспрессивность, Лингвистический энциклопедический словарь. Издательство “Советская энциклопедия”, М., 1990, стр. 591.

⁴⁷ Ч.М.Кобзева. Лингвистическая семантика. Издательство “Эдиториал УРСС”, М., 2000, стр. 22

эн зэрэгцээ үүрэг гүйцэтгэх утгын бүрэлдүүлбэр" гэж үзээд, үүнийгээ яруу үг хэмээн нэрлэж энгийн үгээс утгын багтаамжтайгаар их байдаг гэхсэн. Иймд тэрээр, "... энэ нь үгийн бодит утгаас ялгаран үгийн утгын хийсвэр хэсэгт багтах хүний болон бусад субъектив хүчин зүйлүүд бөгөөд өгүүлэгчийн юм, үзэгдэл, хэлэхүүн тухайн үйлдэлд хандах хандалга, сэтгэл хөдлөл, үнэлэмж, хэлэхүйн үйл ажиллагаанд оролцогчдын харилцааны туршлага, нөхцөл, цаг хугацааг илэрхийлдэг хүчлэл, сэтгэл хөдлөл, дүрслэл, найруулгын өнгө аяс юм гэж үзсэн⁴⁸ байна. Монгол хэлний тэмдэг нэрийн давуу ба бууруу зэрэг нь уг юмын шинжийн их багыг илтгэсэн хүчлэлийг илтгэх нэг арга болох биз ээ.

О.С.Ахманова тухайн эхээс шалтгаалан дүрслэх яруу чанартай болохыг чөлөөт яруу чанар. (адгерентная экспрессивность). Тухайн эхээс бус, уул үгнээ шингэсэн дүрслэг яруу чанарыг чөлөөт бус яруу экспрессивность) гэж ялгаад, эхнийхэд "хорошенькая история", сүүлчийнхэд хорошенькая девушка, златокудрий, жажнуть" гэсэн үгс орно гэжээ.

В.А. Салимовский "найруулгын өнгө аясын доторх янз байдал нь өөр хоорондоо нарийн холбогдох ба зарим нь зааглахын аргагүй байдаг. Нэлээд тархсан янз байдалд 1. нарийн өнгө, 2. сэрэл мэдрэмжээс үүдэлтэй сэтгэл хөдлөл, 3. нийгмийн хэв хэмжээний дагуу, сайн, муу гэсэн үнэлэмж 4. найруулгын үүргээр ялгарах зэргийг багтааж болно⁴⁹ гээд нарийн өнгө буюу яруу шинж, сэтгэл хөдлөл, үнэлэмж гурав нь хэлний нэгжид нэгэн зэрэг нийлж орсон байдаг гэжээ.

сэтгэл хөдлөл	яруу шинж	Нэмэлт утга
бодит утга	харьцааны утга	Үндсэн утга
найруулгын утга	салаа утга	
үнэлэмж "баймж"	дүрслэх ур маяг	

Эд бүгдээс үзвэл, хэлний тухайн нэгж болгонд дээрх нэмэлт утгын зүйлс хамсан ордог байна. Үүнд:

Хөдөө тал нь малаар дүүрэн

Яндан болдоггүй далай шиг

Хөвч ой нь ангаар дүүрэн

Ясан баян нутаг вэ

Хөрсөн доор нь эрдэнээр арвин

Ямар их хувь заяагаар

Хүний хэрэгцээ цөм багтсан

Бид нар эзэн нь болж төрөв (Д.С)

гэхэд эх орныхоо баян тансгаар бахархах сэтгэл төрж байна. Энэ нь .. яасан, .. вэ?, .. ямар.. гэсэн асуух төлөөний үг, ялган асуух бүтээврээр илэрсэн өгүүлбэр нь сэтгэл хөдөлгөсөн санаатай ба "малаар дүүрэн, ангаар дүүрэн, эрдэнээр

⁴⁸ Н.Нансалмаа "Үгийн сан судлал" "Удам соёл" ХХК, 2 дугаар хэвлэл, УБ 2015, 43-44-р т.

⁴⁹ В.А Салимовский Стилистическая коннотация, "Стилистический энциклопедический словарь русского языка, Издательство "Флинта", Издательство, "Наука" М, 2003, стр 432

арвин" гэхэд орсон тэмдгийн нэр нь эерэг сайн үнэлэмж болно. Тэмдгийн нэрийг олшруулж уг зүйлийн шинж чанарыг тодорхойлж зохих ёсоор үнэлдэг байна. Жишээ нь:

Тагтаа хөөрхөн, тагтаа номхон
 Дандаа олуулаа, дандаа тайван
 Тагтаа хүчтэй, тагтаа зоригтой
 Дандаа хүнтэй, дандаа олонтой (Д.С)

“Задарсан Эрдэнээс яаж өшөөгөө авах тухай Итгэлт арга сүвэгчлэн бодсоор Луу гүний хошууны захирагчид хахууль өгч, Халх дөрвөн аймаг, шавь тавд гэгээн цагаан өдөр, гэрэлтэй шар наранд хүн дээрэмдэх гэж оролдсон Эрдэнийг барьж, Луу гүний хошуу тамганд хүргүүлэх зар гаргаж, баригдаж ирсэн цагт нь Галсангаар гэрч болгон өдрийн дээрмийн хэрэгт унагаж, Бадарчийн гарт өгөөд, амьдаар нь хатаахаар шийджээ. (Ч.Л) гэхэд "гэгээн цагаан, гэрэлтэй шар" гэсэн хоршмол тэмдгийн нэр нь чимэг үг болж, улмаар утгыг нь эрчимжүүлж байна. Үүнийг хүчлэл гэнэ. Мөн "хэрэгт унагаа-, гарт өг-, амьдаар нь хатаа- гэсэн утгажсан хэлц холбоо үгс нь дүрслэх ур маяг болж, „Задарсан Эрдэнэ" гэдгийн "задрах (Хэм зүйгээс хэтрэх) гэдэг нь ганцжиж утгажсан хэлц болно.

Алс хол Цастан Төвөдийн оронд янаг амрагийн үгийг мартсан болном буй заа. Зүүн гар нутгийнхаа агийн үнэрийг яахин мартаж билээ. Өвгөд дээдсийн нутаг тань, Таныгаа урин дуудаж байнам бөгөөд ба тэсгэлгүй ширтэн хүлээсээр буй! гэж Анугийн захидалд бичсэн үгийг үзүүт Галданы хатуужин зорьж, нэгэнт шийдсэн санаа цөм биш болж, агшин зуур түмэн зүйлийн бодол төрөөд, сэтгэл жигтэйхэн үймцэв. Оюун билэг хайр сэтгэл хоёр хямралдав. (Б.Р) гэвэл Анугийн захидлын үг нь төрсөн нутаг хайр сэтгэл хоёрыг зэрэгцүүлэн тэнцүүлсэн нь найруулгын яруу (тэгш) шинж бөгөөд найруулах арга барил (стилистикаские приемы)⁵⁰ болно. Мөн Галданы шийдсэн санаа биш болж, сэтгэл жигтэйхэн үймцэв гэсэн сэтгэлийн хөдөлгөөнийг илтгэх ба мөн оюун билиг хайр сэтгэл хоёр хямралдаж буй нь дээрх найруулах арга барил болно.

Галдан минь, заяаны чинь тогтсон цаг боллоо Дөрвөн Ойрдын ноёд зайсангууд өвдөг сөгдөн буруугаа хүлээж, хүзүүгээ сунган бөхийх цаг ирлээ. Би чиний сэтгэлийн хорслыг мэдэв. Ойрдын чуулганаас өргөн дэвшүүлсэн бичиг нь чиний нүднээ эрээн цаас төдийг би бас мэдэв. Гэвч надад бас нэгэн бичиг захиа бий! Түүнийг үзээд, маргааш өглөөний ургахын улаан нарнаар хариугаа хэлээрэй, хүү минь! гэхэд эцгийг нь дотно шадар тэр өтгөс баатар жанжин, өврөөсөө алд хадаг дэлгэн гаргаж, дээр нь Зүүн гар нутгийн сайхан үнэр ханхалсан атга агийн дээр Анугийн захидал талбин барьсанд, энэтхэг орны замбага цэцгийн цааснаа хайртай хүний хэвийн танил сайхан үсэг бүхий захиаг үзүүт, Галдан цочиж бие гэнэт залд хийгээд, өөрийн эрхгүй яаран, хоёр гар сарвайн захиа хадаг сэлтийг авбаас, өтгөн сайд, огт үг хэлэлгүй бусад зайсангуудын хойноос чимээгүй гарч одсон билээ. (Б.Р) гэхэд ярианы ба бичгийн хэлний найруулгыг хосолсон нь яруу тэгш шинжийг агуулжээ. Мөн "Ойрдын

⁵⁰ Н.В.Данилевская Конструктивный прием "Стилистический энциклопедический словарь русского языка, Издательство "Флинта", "Издательство" Наука", М., 2003, стр. 175

нуулганаас өргөн дэвшүүлсэн бичиг нь чиний нүднээ эрээн цаас төдийг би бас мэдэв' гэхэд Галдан уул бичгийг хэрхэн үнэлж байгааг Анугийн захидалтай харьцуулснаас тодорхой мэдэж болно.

Найруулгын зүйлд уул юмын сайн сайн шинжийг тэмдгийн нэрээр илэрхийлэхдээ түүнд захирагдах үгсийг нэг тийн ялгалаар ижилсүүлэн холбож, зүйлийн зэргэд бүтээдэг. Өөрөөр хэлбэл нэг хэлбэрт олон утгыг зэрэгцүүлэн тоочдог. Жишээ нь:

- | | | |
|--------------------------|---------------------------|------------------------------------|
| - номд <u>мэргэн</u> | - төрд <u>нэртэй</u> | - тал-□ <u>дүүрэн</u> хоньтой бол |
| нойр-т <u>сэргэг</u> | түмэнд <u>цуутай</u> | Даваа-□ <u>дүүрэн</u> адуутай бол |
| Үгэнд <u>цэцэн</u> | улсад <u>алдартай</u> | Тогоо-□ <u>дүүрэн</u> сүүтэй бол |
| үйлэнд <u>уран</u> | олонд <u>цолтой</u> | Торх-□ <u>дүүрэн</u> өрөмтэй бол |
| хуулинд <u>шударга</u> | хэзээд <u>сэтгэл амар</u> | - Хурганы ноос хуруу <u>зузаан</u> |
| дээдэст <u>зусаргүй</u> | үргэлж <u>энх мэнд</u> | Төлөгний ноос төө <u>зузаан</u> |
| доодост <u>энэрэлтэй</u> | өвчин тахалгүй | Он мэт <u>тэгш</u> |
| | өлзийтэй жаргаарай | Од <u>мэт гэрэлтэй</u> |
| | | Төмөр <u>мэт бат</u> |
| | | Тэгш сайхан жарга! |
-
- | | |
|------------------------------------|--|
| - Дээвэр хоолойгоороо <u>татуу</u> | - Төрд элч <u>ширүүн</u> |
| Дээл захаараа <u>татуу</u> | Төмөрт хуурай <u>ширүүн</u> |
| Уул оройгоороо <u>татуу</u> | Тохомд зараа ⁵¹ <u>ширүүн</u> |
| Төрсний эцэст үхэх <u>үнэн</u> | |
| Хураасны эцэст дуусах <u>үнэн</u> | |
| Хурсны эцэст тарах <u>үнэн</u> | |


Тэмдгийн нэр нь өмнөх жинхэнэ нэрийг үйлдэхийн тийн ялгалаар захирахдаа уг юмын аль нэг зүйлийн шинжийг онцлон ялгадаг ажээ. Жишээ нь “Удмаараа ороо, унагаараа жороо (ятуу)” гэхэд “удам унага” нь “ятуу” хэмээх шувууны төрөлх шинж бүхий онцлог зүйл болж, түүний “ороо жороо” шинжийг тодорхойлохдоо үйлдэхийн тийн ялгалыг хэрэглэжээ. Энэхүү үйлдэхийн тийн ялгалыг “нэрлэхийн тийн ялгалаар сэлгэн “удам- ороо, унага нь “жороо” гэж болох ба үүний эсрэг “Танхай хүү таван бүстэй, эрүү дутуу, орой цоорхой гэхийг “Эрүүгээр дутуу, оройгоор цоорхой” гэж болно.

Үүнчлэн “Ямба нь их ч яс нь хэврэг” (Хүж) гэх мэт “Ямбаараа их ч ясаараа хэврэг” гэж болно. Хүжийг амьдчилахдаа “ямба, яс” гэсэн хоёр бүхий шинжийг үйлдэхийн тийн ялгалаар онцолжээ.

Цагт нэр буюу үйлт нэр нь нэг талаар үл хувилах шинжээрээ тооны ба тэмдгийн нэртэй адил өгүүлбэрт ямагт хамжсан тодотгол гишүүн болдог (Кидан нар монголын талд урван орж, өлсгөлөнд нэрвэгдсэн тариачдын бослого түйвээн дэгдсээр байв. (Ш.Нацагдорж) Гэвч Чингис хааны өмнө зүгт хийсэн аян дайны булаан эзлэх хөнөөлт шинж чанарыг бид дурдахгүй байж болохгүй” гэж туйлын зөв бичсэн байна (Ш.Нацагдорж) (Өмнө-д); Хоёр жигүүрийн цэрэг, нэг

⁵¹ М.Базаррагчаа Монгол хэлний өгүүлбэрийн үйлдэгчийн ангилал нь "Олон улсын Монголч эрдэмтний XI-р их хурлын "Монгол хэл бичиг судлал" салбар хуралдааны илтгэлүүд, УБ 1917, 8-12-р т.

нь 500 миль, нөгөө нь 350 милийн замыг туулжээ. Чингис 20.000-25.000 цэргийг Тэмүгэ отчигоноор даргалуулан, ар талд хайгуул болгов. Тэр үед монголын дайлаар мордох цэрэг 110000 гаруй байсан бололтой (Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг), нөгөө талаар, өмнөх жинхэнэ нэрийг тийн ялгалаар захирдаг тул тусах ба эс тусах үйл үгтэй адил байдаг өвөрмөц ай юм. Үүнд,



А.Лувсандэндэв “... үйлт нэр нь үйл нэр хоёр айн шинж чанарыг биедээ агуулсан ажээ. Учир иймд үйлт нэрийг нэр үйл хоёрын завсрын биеэ даасан тусгай ай гэж үзэх нь зүйтэй”⁵² гэж үзсэн нь зүйтэй юм. Мөн Го.Мижиддорж “Жич, дээрх үгс шиг болж ирээд, үйлийн тийн ялгалын болон хамаатуулахын нөхцөлтэй нөхөцдөггүй, харин нэрийн тийн ялгалын хийгээд хамаатуулахын нөхцөлтэй бусад нэр үгийн нэгэн адил нөхөцдөг, илтгэх утгын хувьд нэр үйлийн дундын шинжтэй хэлбэржсэн үгс монгол манж хэлэнд байдаг. Тийм үгс нь нэрийн тийн ялгалын нөхцөлтэй, нөхцөлгүй, дан үндэс хэлбэрээрээ байхдаа юмын хийгээд үйлийн мэдэгдэхүүний алийг нь ч илтгэж чаддаг”⁵³ гэж цагт нэр (үйлийн ялгаврын нэр Го.М.)-ийн шинжийг тодорхойлжээ. П.Бямбасан багш цагт нэр нь үйл үгийг жинхэнэ нэртэй тодотгон холбох нөхцөл гэж үзэхдээ 1. Үйлт нэрийн нөхцөл идэвхгүй язгуурт залгаж болдоггүй, язгуураас хол тохиолдоно. 2. Үйлт нэрийн нөхцөлийг үйл үгийн үндэс бүрд “нэр үйлийн нөхцөл шиг залгаж болно. 3. Нэр үйлийн нөхцөлтэй адилаар үйлт нэр нь парадигма үүсгэж болно. 4. Үйлт нэрийн нөхцөл нь үйл үгийг жинхэнэ нэрнээ захируулан холбодог. 5. Үйлт нэр нь дагавартай адил нэг зүйлийн дохиог өөр зүйлийн дохио болгож чадахгүй, зөвхөн уул дохиог хувилгана”⁵⁴ гэж үзсэн байна. Е.К.Скрибник “Үйлт нэр нь үндсээрээ нэрийг тодотгосон бүтэц үүсгэдэг (Гэмгүйхэн лэ хүн, ха, - гэжэ бэриез үни удаан шэнжэн шарайшал=хан Норжомо хүгшэн хүүлэй хүүлдэ бодобо) гээд, үйлт нэрээр тодотгосон бүтцээ жинхэнэ ба хуурмаг гэж хоёр ангилжээ (1. Сугтаа хира=хан нүхэд-ми ерэшоо ха юм. 2. Ахынхаа энэ колхозой түрүүлэгшэ бай=хан саг=та үлдэжэ түража ябахагүйб)”⁵⁵ Тэрээр, нэрийн тийн ялгалт үйлт нэр бүхий бүтэц, дагавар үгт үйлт нэр бүхий

⁵² А.Лувсандэндэв, Монгол хэлний үгсийн аймгийг ангилах тухай асуудалд”, Монгол хэл бичгийн зарим асуудлууд, Уб., 1956. 29-р т.

⁵³ Го.Мижиддорж “Монгол, манж бичгийн хэлний харьцаа”, Уб., 1976.42-43-р т.

⁵⁴ П.Бямбасан, Үйл үгийн тодотгон холбох нөхцөл, “Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт” Уб., 1987, 90-93-р т.

⁵⁵ Е.К.Скрибник, Полипредикативные синтетические предложения в бурятском языке. Новосибирск, 1988

бүтэн, холбоот үйлт нэр бүхий бүтэц, үйлийн тийн ялгалт бүтэц гэж ангилсан нь цагт нэр нь нэрийн тийн ялгалаар хуурмаг хувилдгаас эхтэй ажээ. “Очих-ын тулд, явсны дараа, уншдаг мэтээр” төгс бус өгүүлэхүүн бүтээдэг нь тодотгол гишүүн өгүүлбэрийн хувилбар юм. А.Боброников тухайн нэг өгүүлбэрт буй гишүүнийг тодотгосон өгүүлбэрт байдаг. Түүнийг тодотгол гишүүн өгүүлбэр гэж үзсэн байдаг. Жишээ нь:

Амтат олон жимсээр дэлгэрсэн галбарбас мод минь
 Асар хүчин төгссөн цаст уулын цагаан арслан минь
 Арга хүчин хоёрыг тэгш чадагч гарди хөлөг минь
 Алдарт төрсөн богд эзэн минь

Мөн тэрээр цагт нэр нь нэрийн тийн ялгалаар хувилж, гишүүн өгүүлбэр болдгийг өгүүлсэн нь үйлт нэр нь тодотгол гишүүн өгүүлбэр болдгийг үүсэлтэй хувилбарууд юм. Жишээ нь, а. Андгар хийснийг шадар нь бид эвдэв. Чамайг гэртээсээ гарахад чинь чамд занасан бүлгээ би. Эцэг охины зүрхэнд ус цацсанаар үхэдхийснээс сэргэж, ийн хэмээн айлтгав. Үүрд зовон үхсэнээс эдүгээ үхсэн ч амар буй. Судраас сонссоноор номуудыг мэдмүй. Сонссоноор хилэнцээс ичмүй. Сонссоноор хэрэггүйг тэвчмүй. Сонссоноор нярвааныг олмуй. Б. Энэ тарнийг долоонтоо өгүүлсний хойно үндсэн тарни өгүүлэгдэхүй. Нэг мориор довтловч арван мориор довтолсон мэт дуугармуй. Хувьгүйгэж гурван эрдэнийн эрдмийг эс үзсэн тэр нь өөрт баривчлагагүйн гэм мөн буй за. Гурван эрдэнэд эрдэмгүй нь бус.⁵⁶ Хэрэв цагт нэрийн дагавруудыг нөхцөл хэмээн үзвэл түүний дараа нэрийн тийн ялгалын нөхцөл орж байна гэж үзэх үү. цагт нэр нь арын тодотгуулагч нэрээ гээснээс нэрийн тийн ялгалаар хуурмаг хувилдаг ажээ. Энэ нь тэмдгийн нэр хуурмагаар хувилдагтай адил юм.

Д.Заяабаатар цагт нэр бүтээх залгаврыг, тодотгон холбох нөхцөл гэж⁵⁷ үзсэн ба *küci ögüg-sed sayid aran-i*” гэж олон тооны дагавар авсан жишээг дурджээ. Энэ мэтээр цагт нэрийн дараа "ala-ya-či-n, ungsi-ya-či-n, sayu-a-či-n, dabki-ya-či-d, sayu-үчи-d, oči-үса-d, surtaqu-n, ögüle- kü-n, yabu- qüiца” гэх мэтээр дагавар авч буй нь цагт нэрийг нөхцөл гэж бүрэн төгс тооцох боломж хомс буйг илтгэнэ. Тэмдгийн нэр нь юмын өөрийнх нь шинж чанарыг зааж буй тул уг нэртэйгээ нөхцөлөөр холбогдохгүй, зөвхөн тэг үндсээр хамжин тодотгодог. Харин нэр үйлийн нөхцөл нь хоёр юмсын хоорондох харьцааг заадаг.⁵⁸ Цагт нэр буюу үйлт нэр нь үйл үг болгоныг хувилгах нөхцөлийн шинжтэй боловч тэмдгийн ба тооны нэр мэт тэг үндсээр жинхэнэ нэрэнд хамжин холбогддог хоёрдмол шинжтэй болно.

Тэмдгийн нэр нь үйлдэх, өгөх орших гарахын тийн ялгалаар өмнөх жинхэнэ нэрийг захирах нь тогтвортой зайлшгүй шинж мөн бөгөөд тогтворгүй

⁵⁶ А.Бобровников. Грамматика монгольско-калмыцкаго языка. Казань, 1849. Стр. 264-303

⁵⁷ Д.Заяабаатар, XIII-XIV зууны монгол бичгийн дурсгалын авиа зүй, үг зүйн тогтолцоо. Монгол улс. Уб., 2011. 120-131-р т.

⁵⁸ М.Базаррагчаа, Өгүүлбэрийн гишүүдийг холбох, хамжих аргын учир “Монгол хэл шинжлэл” м. VII. Уб., 2002, 28-р т.

санамсаргүй шинжийг энэ гурван тийн ялгалаас бусад тийн ялгалын нөхцөлөөр өмнөх жинхэнэ нэрийг захирдгаас үзэж болно. Үүнд:

А.1 N_{sub}^{nobi} - Ганзага-□ татуу⁵⁹, Ганзага-□ хоосон, Арван хуруу-□ тэгш, Ам-□ түргэн, Ам-□ хатуу, магнай-□ тэнүүн, Ам-□ задгай, Ам-□ султай, ам-□ халамцуу, ам-□ хуурай байдаггүй. зүрх-□ муутай, нүүр-□ бүтэн гарах, нүд-□ нь том болох, нар-□ битүү, мөр-□ бүтэн, магнай-□ тэнүүн, элэг-□ нимгэн (өр-□ нимгэн), чих-□ урт, чих-□ хатуу, чих-□ зөөлөн, хүзүү-□ дутуу, хумс хуруу-□ урттай, хөл-□ хүнд, хөл-□ хөнгөнтэй, ухаан-□ богино, өвөр-□ суд, од-□ муутай төрөх, нэр-□ бүтэн.

- 2. N_{sub}^{gene} шилний хонхор харуулах, Жуучин бууны хугархай, Үдийн хугархайн ноён, нүдний булай болох, нүдний цагаанаар үзэх, мордохын хазгай, газрын мухар, амны хишигтэй,

Б. - 3. N_{sub}^{comi} Алга үзэхтэй адил, (илт мэдэгдэх) урьдах захидал нь дараагийн захидалтай бараг ижил байдаг. (Ц.Д) Ялдам зөөлөн залуу цэцгийн уран навчис Янжинлхамын хуруутай адил гэж үл эрэмшихүй... (Х.Гаадан)⁶⁰. Энэ ертөнцөд олдохуйяа бэрх будда эрдэнэт чандманьтай үнэхээр адил аа (Х.Гаадан) Их дэлж харвал есөн зуун алд газар харваж, татуу дэлж харвал таван зуун алд газар харвадаг хүнтэй адил хүн биш, хүнийг идэх мангас, хучит хар Хасар тэр хүрч ирж явна. (МНТ) Гэвч ноёнттой өшөөтэй бол хонгогүй, нохойтой өшөөтэй бол хормойгүй гэдэг дэмий үг биш болохоор Гомбожав хошууны хөрөнгөөр хөлөө хүрэх газар бүхэнд хээл хахууль цугтаж байгаад, эзэн ноёнттойгоо харгалдсан тэрсүүд албатыг Улайстайн бат гүнд орхив. (Ч.Л)

Ингээд нэг мэдэхэд Гэрэлийн үг Довчинд Богдын зарлигтай адил болов. (Ч.Л)

Би ч бас л энэ хүнтэй яг л адилхан. (Ч.Л)

Энэ нь Будын зугтаасан хэрэгтэй тун ч төстэй байсанд санаа амарч, өөрийнхөө тухай ний нуугүй ярьж, сэтгэлээ дэлгэлээ (Б.Цэрэнжамц) Энэ нь зөвлөлтийн уран зохиолд миниатюра гэж нэрлэдэг төрөл зүйлтэй ойролцоо юм. (Ц. Хасбаатар). Олзвой чи урьд хоёр хүнтэй адил гэж бүү сана. (Гэсэр) Батнасан насаар Доржготовтой чацуу. Тэд чадлаараа Баттай яг тэнцүү юм байна. Ургаж хагдрах, мартаж санахын сав их орчлонгийн дунд Цэвэг хүнтэй адил амьдарч ганц зүйлд зориг зүрх алдаж, үзээд өнгөрүүлсэн, амьдрал хэмээн бодож, хань ижил үр хүүхэдгүй дал хүрэв. (Ш.Циен-Ойдов). Таван хүүхдийн эцэг, аймгийн баазын аварга жолооч надад ямар амьдрал юу дутаж байна вэ? Ерөөс оростой их ойролцоо суръя гэж оролдоод, зав чөлөө гаргаад, үзэж орхивол болох л хэл юм. (Б.Энэбиш)

- 4. N_{sub}^{comp} Алт шиг өнгөтэй байхыг

Алт шиг үнэтэй байхыг

Алт шиг хүн байхыг (сайн хүн байхыг)

Ахин дахин хүснэм (Н.Нямсүрэн)

"Арчсан толь шиг (цэвэр, тунгалаг). Аягын чинээ (бага), Бээлийн чинээ (өчүүхэн). Гал ус хоёр шиг (тас зөрүү), Газар тэнгэр шиг (өөр), Дэнгийн

⁵⁹ Г.Аким Монгол - Орос, Орос - Монгол өвөрмөц хэлцийн товч толь, улсын хэвлэлийн газар, УБ 1985, 14-80-р т.

⁶⁰ Х.Гаадан Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл, сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар, УБ 1986, 75-р т.

эрвээхий шиг (хөнгөн), зургийн хуар шиг (хөөрхөн), нар сар шиг (ачтай), өдөр шөнө шиг (ялгаатай), нойтон хамуу шиг (нялуун), нүх шиг харанхуй, өдрийн од шиг ховор салхины дэвүүр шиг (хөнгөн) ус цас шиг (даамгай орчуулах), хаврын тэнгэр шиг (ааштай), хадны цуурай шиг (хоосон), хайлсан тугалга шиг, хатсан борц шиг (хатуу), хонь чоно хоёр шиг (өшөөтэй), хуй салхи шиг хурдан. Хуруун чинээ (жижигхэн), цэврүү шиг (цэвэр), шаасан гадас, шахсан бяслаг (шиг бөх бат), чигчийн чинээ (бага) Шуудайд хийсэн үхрийн эвэр шиг (эв түнжингүй), эрхийн чинээ (бага), (Г.Аким, Дурдсан зохиолоос)

Ванган тайзан дээр алахаас наагуур, амьдаас цаагуур загнаж байсан мөртөө энгийн цагт анд нөхрийн ёсоор алаг бяруу шиг номхон (Д.П). Зарлага гэдэг аргал усны үхэр шиг амар заяа гэж үгүй (Д.П). Эртний арслан зааны соёо шиг хув шар өнгөтэй, царай нь дотроо чухам юу бодож байгааг мэдэгдэхгүй, хөндий цээжинд гал шатавч утааг хамраар гаргахгүйн сургууль хийсэн шинжтэй дөрвөн бичиг, таван номд илэрхий тэр үеийн бичгийн байдалтай. (Б.Р), Эх хүний сэтгэл ботготой ингэ шиг уяхан, бялзуухай шиг гэнэхэн юм хойно доо. (Н.Нагаанбуу), Хүн гэдэг бууны гол шиг харанхуй амьтан, эрдмээр л сүмбэдэж, гэрэл гэгээ оруулж байхгүй бол гадна нь мянган зул асаагаад ч нэмэргүй. (Д.Батбаяр) Тэдний нэг гэвэл овоо малтай бэлтэй айлд заяасан тал мэт уужим сэтгэл, гал шиг дүрэлзүүр араншинтайгаа, тэгтлээ харанхуй мунхагтаа ногтлуулаагүй Хүрэлбат хэмээх хөдөөх хүдэр эр бөлгөө. (С.Пүрэв). Хааяа нэг цэрэг эр дэр дэр гүйлдэх, нүдний үзүүрт тэртээ жалга хөндийгөөр хулангийн сүрэг зэгийж давхилдахаас өөр гойд торох юмгүй, дэндүү нэг хэвийн амьдрал дунд даргилсан цай шиг хангал залуу насаа өнгөрүүлнэ гэхээс миний дотор үе үе бачуурч, хаяад зугтаачихмаар санагдах удаа ч бий (Д.Цэнджав) (Уран зохиолын жишээг Ж.Бат-ирээдүйн "Монгол үгийн утгыг үзүүлэх шинэ толь бичиг хэмээх номоос авсан болно.)

Тэмдгийн нэр нь өмнөх жинхэнэ нэрээ “Ганзага-□ татуу, Хөл-□ хүнд” гэх мэтээр нэрлэхийн тийн ялгалаар захирах ба өгүүлэхүүн болсон тэмдгийн нэр нь уул жинхэнэ нэрийнхээ өмнө тэг үндсээр хамжсан тодотгол гишүүн байх ёстойгоос байр сэлгэсэн тул ингэж нэрлэхийн тийн ялгалаар захирах нь хувилбараас үүсэлтэй юм. Үүнийг байр шилжих буюу транспозиция гэдэг⁶¹. Тухайлбал, татуу ганзагатай - ганзага татуу, хүнд хөлтэй- хөл хүнд гэж байр сэлгэсэн байна. Харин "бор-лог, бая-лаг, гоё-мсог, их-мсэг, цэц-рх-г, бор-нгуй, сай-хан, муу-хай” гэх мэтээр тэмдэг нэрээс тэмдэг нэр "ай-мхай, ай-мтгай, хуур-маг, хана-гар, хур-аа-нгуй, зорь-мог, дад-маг, дүүр-н хат-уу, чад-уу, яд-

⁶¹ О.С.Ахманова тухайн үг нь өгүүлбэрт орохдоо хувирах ёсыг транспозиция гэж товч тайлбарлаад, метатеза (перестановка, пермутация, транспозиция) (тонгорох ёс, солигдох), гипостазис, метабазис (ай солигдох), трансформация (цөм бүтэц хувирах), транслатив (хувилах, хувилах тийн ялгал) зэрэг нэр томъёог хамтатгасан байна. (Словарь лингвистических терминов, М, 1966, стр. 480)

Ш.Балли жинхэнэ нэр нь тэмдгийн нэр болох, эсвэл “Чи худал хэлж байна” гэсэн өгүүлбэрийг “Чи миний худалчийг”, Чиний худал хэлэхийг би мэдэж байна” гэх мэтээр хувиргахыг үүргийн хувиргал (Функциональная трансформация) гэсэн ба “дулаан орны ургамал (тропическая растительность) гэхээс дулаан орны халуун (тропическаяжара) гэж үүсэхийг “утгын хувиргал” гэжээ. *Общая лингвистика общая лингвистика и вопросы французского языка*” Издательство иностранной литературы. М., 1955, стр. 131

уу, дар-мал, үх-шир-мэл, ха-нхай хял-р, хөгж-үүн, хөх-үүн, хал-уу-н, өмнө-д, дотоо-д, өвс-рх-үү нэр-лх-үү сөө-нгө тогт-нги гэх мэтээр өөр өөр үгсээс тэмдэг нэр үгээхийг хэлбэр хувирах (трансформация) гэж болно. Ингэж нэг үгсийн айгаас нөгөө үгсийн айд шилжихийг Е.А.Земская “байр шилжих” гэсэн нь хэлбэр хувилах ёсыг нэрлэжээ.⁶² С.А.Крылов Монгол хэлний бүтээврийн авианы хувилбарыг бүтээврийн хэлбэр хувирах (морфемная трансформаторика) хэмээн нэрлэсэн байна.⁶³ Жишээ нь -рхэ, лхэ, уур-уул, -ууги-уули гэсэн дагавар, -гуу-луу гэсэн нөхцөлийг дурдаж болно. Түүнээс гадна, “mǝngǝ” гэвэл деньги, “серебро” гэсэн ижил язгуурыг авианы ижил цогцоор илтгэхийг квазиомономия” (хуурмаг ижил нэр язгуур) гэсэн ба “Халх Монгол хэлэнд ер нь төвд тэмүүлэх бүх хэлэнд, тухайлбал, алтайн хэлнүүдэд тодотголын байрыг хэлбэрийн хувьд, зохицох үгийн өмнө орохтой адилтгаж болно. Энэ нь түүний захирах чадвараас шалтгаална” гэснийг тэмдэг нэрийн захирах чадвартай холбон ойлгож болно. Жишээ нь ... тэр цаг, тэр улирал жинчин хүний сэтгэлд бусдаас илүү нэвчин шингэж, зүрхний угт нь хоногшдог ажээ” (П.Лувсанцэрэн) гэхэд “илүү” гэсэн тэмдгийн нэр нь гарахын тийн ялгалаар бусад (цаг, улирал) -аас ” гэж захирсан нь тоо хэмжээний хувьд давуу байгааг харьцуулжээ. Үүний “бусдаас” гэдгийн нөхцөлийг үйлдэх, өгөх оршихын тийн ялгалаар сольж үл болох бол

- "Нойтон -д\оос\ цавуу бөх

Махан-д\аас\ элэг бөх

амьтан-д\аас\ заан бөх

- Тостой-д\оос\ тогоо хар

Билигтэй-д\ээс бэх хар гэж сольж болно. Учир нь энэ жишээний хувьд өгөх орших, гарахын тийн ялгал нь хоёулаа "бусдаас онцлон ялгасан" утгаараа ойролцоо байна. Тэгвэл

Газар үндсээр баян

Тэнгэр одоор баян

Далай усаар баян" гэхэд үйлдэхийн тийн ялгал нь "үйлдэгч хэрэглүүр" заасан утгатай тул "эрхэн үйлдэгч"- ийн утга бүхий нэрлэхийн тийн ялгалаар сольж болно. Иймд:

"Газрын үндэс-□ баян

Тэнгэрийн од-□ баян

Далайн ус-□ баян" гэж болох ба "Газраас\т үндэс баян, тэнгэрээс\т од баян, далайд\г\аас ус баян гэж хувиргавал " бусдаас онцлон ялгасан "утгатай" болно. Энэ нь зөвхөн газарт л, газрын хувьд гэвэл" гэсэншүү утга бий болж болох юм.

Гэвч, ... хээрийн цэвэр агаарыг цээж-□ ээр дүүрэн татаж, бодолд автан мэлмэрч явах бас ч сайхан байдаг аа. (П.Лувсанцэрэн), .. Жанцан хэлсэн үгэн-дээ\ээсээ их л сэтгэл хангалуун инээмсэглэв. (П.Лувсанцэрэн), .. ээжийнхээ дээлийнхээ үлдцээр хийсэн өмднөөс өөр хувцасгүй борхон ходоодтой шантгар жаал аав ээж хоёрынхоо уй гашуу болж байгааг гайхан, нүд бүлтэлзүүлэн

⁶² Е.А. Земская Современный русский язык, Словообразование, Издательство, Просвещение, М. 1973 стр 192

⁶³ С.А.Крылов Теоретическая грамматика современного монгольского языка и смежные проблемы общей лингвистики Т. I. Издательская фирма. Восточная литература, М. 2004 стр129, 143

ширтэнэ (Д.Намдаг) -Нэг жил гэдэг надад тун урт хугацаа (Д.Намдаг). Жанцангийн хойноос үс нь их ургасан, чац-□ томтой залуу эр хар булигаар богц барьсаар толгой-□ нүүцгэн гарч ирээд наран сөрөг анивчин ... Унаа морь нь түүнээс ч хол давхих шинжгүй байлаа. (С.Дашдооров). Тэгээд ч уяа шонгоо эргэлдэн харуулдахаа больж, уул уулын бараа толгой ширтэн, ухаан бодлоо холын холд бэлчээхийг хичээн, орон гэрт хоргодомтгой муу зангаа гээжээ. (С.Дашдооров) Төмөрийн сэтгэл баяраар дүүрэн байлаа (Ч.Л) зэрэг жишээнээс үзвэл, дээрх тийн ялгалын нөхцөл тэр болгон өөр хоорондоо сэлгээд байдаггүй ажээ.

Тэмдгийн нэр нь өмнөх жинхэнэ нэрээ үйлдэн өгөх орших, гарахын тийн ялгалаар захирдаг шиг бүхэл бүтэн өгүүлбэрийг захирдаг. Жишээ нь:

- Одоо бид зэвсэг хэрэглэх-ээс өөр замгүй болжээ. (Ч.Л) Дорж тавны цэргийнхээ хамт хэдэн пүүсний хашаанд орвол эрүү өвдөг нь нийлэх шахсан хөгшин луухаанаас өөр хүн байсангүй. (Ч.Л) Эрдэнийн тавьсан юм бусад цэргийн юмнаас шал өөр зүйл шиг Сүхбаатарт санагджээ. (Ч.Л)
- Өсөхөд шүд цагаан Урсахдаа ус хөнгөн
Өглөхөд үс цагаан Хийсэхдээ өд хөнгөн
Үхэхэд яс цагаан Өргөхөд өвс хөнгөн
- Туухад гахай нэг хэцүү
Туулахад тал нэг хэцүү
Тоолоход од нэг хэцүү

Түүнээс хойш би Ухнаадоржоос холхнуур явах болсон юм. (С.Э) Цөцгийн тосны төлөвлөгөө биелүүлнэ гэдэг ааруул хурууд хийхээс илүү чухал ажил болжээ. (С.Э) Залуу зандан насны минь хоёрхон жилийн урттай тэр хэрчим эргэн санахад юмгүй богинохон гэлээ ч хаа хойно, тэртээ хол Цагаан турууны голын хөвөөнд, нутгийн тэнгэрээс мишээн ширтсэн цэнхэр нүдийг мартамгүй болгосноороо хорвоод ноогдсон насны минь хугацаатай тэнцүү урт ажээ. (С.Э) гэсэн жишээнд буй тэмдгийн нэр нь өмнөх үгээ зохих тийн ялгалаар захирсан тул нөхцөл өөр хоорондоо сэлгэж болохгүй байна.

Эдгээр жишээ нь "цэцэгсээр арвин тал, цэцгээс хөөрхөн бүсгүй, цэцэгт дуртай хүн" гэх мэттэй адилаар тэмдэг нэрнээ захирагдсан жинхэнэ нэр нь гээгдсэнээс хамжсан тодотгол гишүүн өгүүлбэр нь байц ба шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэр болон хувирчээ. Үүнийг:

цагт нэр (-сан, даг, х, аа..) + жинхэнэ нэр "гээгдэх" + аар, д, аас + тэмдгийн нэр

а. Залуучууд морь унахаа бараг болиод дандаа мотортой унаагаар давхицгаахыг муу гэх ямар үндэс байхгүй. (.. давхицгаах + (жинхэнэ нэр "гээгдэх")-□ нь муу)

б. Наадам үзэж нутгийнхаа өвгөд хөгшидтэй золгож, үеийнхэнтэйгээ хуучилж, ямар ч үгүй явснаа төрсөн нутгийнхаа захад иртэл гэнэт зүрх минь доголдон чичрээд, эхний тааралдсан айлд бууж хэвтэхээс өөр аргагүй болов. (С.Э) ... хэвтэх (жинхэнэ нэр)- аас өөр аргагүй болов. Харин “явснаа гэдгийн

“-снаа” нь нэгэнт үйлийн азнах тийн ялгал болон хувирсан тул ард нь жинхэнэ нэр (үе, цаг) сэргэхгүй болжээ.

Тэмдгийн нэр нь юмс үзэгдлийн шинж чанарыг зааж, ямагт уул жинхэнэ нэрийн өмнө хамжин орж тодотгол болохдоо хагас өгүүлэхүүний шинжийг агуулдаг. Тухайлбал: "Зузаан өрөм, гүн худаг" гэвэл 1. бай-, бол-, а-, бү- гэсэн туслах ба дутмаг үйл авч "зузаан байсан өрөм “гүн болсон худаг, зузаан асан өрөм, гүн байдаг худаг” гэх мэтчилэн үйлшиж, өгүүлэхүүн гишүүн болно. 2. өмнөө жинхэнэ нэрийг заахаас бусад тийн ялгалаар захирдаг. (хуруу хиртэй зузаан өрөм, гурван алд хирийн гүн, худаг) хальс шиг нимгэн даавуу, цас шиг цэвэрхэн даавуу, цээлээс гүн худаг, цэцнээс дээр тэнэг хүн, шараас хашин морь, хувцсандаа нямбай бүсгүй, ажилд маруухан залуу, биеэр тавир бяруу, идэш уушаар тарчиг жил, ташаагаараа урт дээл, хоолойгоороо уужим захтай дээл, насаар ах хүн) 3. Тэмдгийн нэр нь жинхэнэ нэрээ захирахдаа зөвхөн харьяалах, жишихийн тийн ялгалаар, орон цагийн нэр нь жинхэнэ нэрийг захирахдаа зөвхөн харьяалах, гарахын тийн ялгалаар, тэмдгийн нэр нь жинхэнэ нэрийг захирахдаа үйлдэх өгөх орших гарахын болон нэрлэх харьяалах, хамтрах, чиглэхийн тийн ялгалаар, үйл үг нь өмнөх жинхэнэ нэрийг бүх тийн ялгалаар тус тус байна.

Резюме

Как считают ученые, с точки зрения речи, в монгольском языке управление прилагательных существительными осуществляется всеми падежными флексиями кроме винительного, но с точки зрения языка, прилагательные подчиняют себе существительные флексиями орудного, дательного-местного и исходного падежей. Это можно считать сильным управлением прилагательного. Например: элгээрээ энх амгалан (мир и согласие), толгойтой үснээс их (работа по горло), нүдэнд дулаан (приятный на вид). Если прилагательные подчиняют себе предыдущие существительные другими падежными флексиями Кроме вышесказанного, зайдешь это можно назвать слабым управлением.

В потоке речи прилагательные в монгольском языке управляют предыдущие существительные именительным падежом, что объясняется переходом прилагательных на глагольную позицию. Примеры: мухар газар (тупик) - газар-□ мухар (в тупик зайдешь); татуу ганзага (короткая торока) - ганзага-□ татуу (неумелый, скупой). Когда прилагательный управляет существительное родительным падежом, тогда это существительное станет определением принадлежности. (Газрын мухар – край земли)